MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,144.642... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.05.26. Баасан. №104 (4718) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

**УЛС ТӨР**

О.БААСАНХҮҮ: ХИЙРХЭЛ ХЭРЭЭС ХЭТЭРЛЭЭ

II нүүрт

**ДЭЛХИЙ**

МАНЧЕСТЕРЫН ХАЛДЛАГЫН НУУЦ МЭДЭЭЛЛИЙГ АНУ-Д ЗАДРУУЛСАН УУ

IV нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +32
Шөнө +14

Дугаарын 60 мөр

## Хоцрогдсон баярын “амтгүй цэс”-ээ больчихооч

Г.ГАНЧИМЭГ

Хүний амьдралын бүхэл бүтэн хоёр үеийн туршид огт өөрчлөгдөөгүй дадал зуршил гэж бас байх юм. Энэ нь дэвшилттэй сайн зүйл бол яая гэхэв. Гэтэл ямар ч үр ашиггүй, хоцрогдсон зүйлийг бусад хүүхэд ч гэсэн ингэдэг учраас хийж байгаа нь утгагүй. Хонхны баярыг их, дээд сургууль болон ерөнхий боловсролын дунд сургууль төгсч байгаа хүүхдүүд эрдмийн баяр гэдэг утгаар нь хөнгөхөн тэмдэглэх нь зөв гэж дийлэнх эцэг, эхчүүд үздэг юм билээ. Харин энэ арга хэмжээ мөнөөх баярлуулахыг хүсээд байгаа хүүхдүүддээ ямар сэтгэгдэл үлдээдэг бол. Хонхны баярын хөтөлбөр бүх сургуульд ижилхэн.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

# Б.Чойжилсүрэн: МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГТ НОГООН ГЭРЭЛ АСЛАА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ӨНӨРТОГТОХ

Өнгөрөгч лхагва гарагийн үүрээр 04.00 цагийн үед ОУВС хуралдаж Монгол Улсын “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдах хүсэлтийг зөвшөөрсөн билээ. Тодруулбал, шийдвэр 06.00 цагийн орчим эцэслэн гарч, 24 улс орны захирлууд санал нэгтэйгээр дэмжсэнийг өчигдөр өглөө олон нийтэд зарласан. Тэгвэл өчигдөр 14.00 цагт Сангийн яамны сайд Б.Чойжилсүрэн, дэд сайд Х.Булгантуяа, Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, тэргүүн дэд Ерөнхийлөгч О.Эрдэнэбилэг, ОУВС-ийн Монгол дахь суурин төлөөлөгч Нэйл Сакер нарын албан тушаалтнууд хөтөлбөр албан ёсоор хэрэгжиж эхэлснийг олон нийтэд зарлалаа.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

Ч.ЧУЛУУН

Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх “Ноён уул”-ын асуудлаар хуралдаж, эцсийн шийдвэрээ гаргасан байна. Уг шүүх хурлаар, энэ сарын 2-ны өдөр Захиргааны хэргийн Анхан



## “Ноён уул”-ын асуудлаар Анхан шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгов

шатны шүүхээс актын биелэлтийг түдгэлзүүлэх тогтоол гарсныг хариуцагч Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, гуравдагч этгээд болох Засгийн газар, “Сентеррагоуд Монголия” ХХК-ий итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нарын гомдлыг хянан хэлэлцэж, Анхан шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгожээ. “Ноён уул”-ын асуудлаар захиргааны хэргийн Анхан шатны шүүх актын биелэлтийг хоёр удаа түдгэлзүүлснийг Давж заалдах шатны шүүх хянан хэлэлцээд хүчингүй болгож, эцсийн шийдврээ гаргалаа. Хуульд зааснаар Анхан шатны шүүх асуудлыг нэг удаа шийдэх ёстой атал хоёр удаа хянасан нь алдаатай шийдвэр болсон гэж Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх үзсэн байна. Хамгийн сүүлд өнгөрсөн оны тавдугаар сард уг асуудлаар Анхан шатны шүүх хурал хуралдаж, актын биелэлтийг хоёр дахь удаагаа түдгэлзүүлсэн тогтоолыг гаргаад байсан юм. “Ноён уул”-ын хэрэг нь нэг жил зургаан сарын хугацаанд Анхан шатны шүүхээр хэлэлцэгдэж байгаа боловч үндсэн маргааныг авч үзээгүй байгаа. Тиймээс дараагийн шүүх хуралдааны тов одоогоор тодорхойгүй байна.

## БНЧУ-ын элчин сайдын яамандаа талархъя

Бүгд Найрамдах Чех Улсын элчин сайдын яам 1953 оноос хойш Монгол улсад албан ёсоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд манай улсын хувьд олон салбарт хамтын ажиллагаа тогтоож, тогтвортой найрсаг харилцаатай яваа орнуудын нэг юм.

Бүгд Найрамдах Чех улс нь Монголын залуу өвсөр үеийнхний боловсролын хөгжилд чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх сургалтын төв байгуулах /дархан хот, дон комко сургалтын төв/, эрүүл мэндийн салбарт I амаржих эмнэлэгт төрөх ээжүүдэд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, байгаль хамгаалах салбарт ялангуяа “Прижевальскийн адуу” хэмээн алдаршсан тахийг уугуул нутагт нь авчирч, унаган байгальд нь нутагшуулах ажлууд зэрэг хоёр орны хамтын ажиллагаар бэхжүүлэх үйлсэд тодорхой хувь нэмэр оруулах олон олон төслүүдийг хэрэгжүүлсээр байна.

Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ивана Гроллова болон тус яамны монгол болон гадаад мэргэжилтнүүд сүүлийн таван жилийн хугацаанд тус ЭСЯ-ны бодлогыг үргэлжлүүлж, ялангуяа нийгмийн хариуцлагын хүрээнд томоохон ажлуудыг идэвхийлэн хийж байгаа нь монголчуудад элэгтэй ажил болон хэрэгжиж байгаа талархууштай.

Мөн Бүгд Найрамдах Чех Улс руу зорчиг иргэд болон аж ахуй нэгж байгууллагуудын визний хүсэлт, визтэй холбогдох санал, асуудлыг тус элчин сайдын яам түргэн шуурхай шийдвэрлэдэг болж үйл ажиллагаагаа улам сайжруулж байна. Энэ нь тус элчин сайдын яамны Монголын ард түмэнд найрсаг байдгийн илрэл болсон төдийгүй улс орны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулан явдалд гүнээ талархал илэрхийлж хоёр орны цаашдын хамтын ажиллагаа урт хугацаанд, тогтвортой үргэлжилнэ гэдэгт итгэлтэй байна.

## БАТСҮМБЭР СУМЫН СҮҮ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧИД “МОНФРЭШ” ҮЙЛДВЭРТЭЙ ТАНИЛЦЛАА

Монголд анх “ТетраПак” технологийг нэвтрүүлж байсан МонФрэш компаний хамт олон бусад үйлдвэрлэгч нараас түрүүлж эх орны үнээний цэвэр сүүг “ТетраПак” технологиор үйлдвэрлэн хэрэглэгч олондоо бэлэг барьж байсан. Мөн хувийн хэвшлүүдээс анх удаа Монгол орныг хамарсан сүү бэлтгэл нийлүүлэлтийн тогтолцоог бий болгохоор зорин ажиллаж байгаа ба Улаанбаатар хотын ойр орчмын Гачуурт тосгон, Төв аймгийн Батсүмбэр, Борнуур, Мөнгөнморьт Сэлэнгэ аймгийн Баруун хараа, Зүүн хараа зэрэг орон нутагт сүү хүлээн авах зөөврийн хөргүүрийн төвүүдийг ашиглатад оруулан малчид, фермерүүдээс шингэн сүүг жилийн дөрвөн улирлын турш хүлээн авч, өөрийн үйлдвэрлэдэг сүү, сүүн бүтээгдэхүүнүүддээ 100 хувь эх орны сүүгээр үйлдвэрлэн хэрэглэгчиддээ хүргэж байгаа билээ.



Мөн БИЕЭ БОДООРОЙ брэндийн үнээний цэвэр сүүгээр үйлдвэрлэсэн ТАРАГ, ААРЦ болон Монгол үнээний цэвэр сүүгээр франц технологи ашиглан дөрвөн нэр төрлийн бяслаг үйлдвэрлэн дотоодын зах зээлд нийлүүлж байгаа. Тун удахгүй экспортонд гаргахаар ажиллаж байгаа юм. Энэ удаад “МонФрэш” компани Улаанбаатар хотын сүү нийлүүлэлтийн дийлэхийг хангадаг Төв аймгийн Батсүмбэр сумын нийт сүү бэлтгэн нийлүүлэгчдийг хүлээн авч үйлдвэртэй танилцуулан, цаашид хамтран ажиллах төлөвлөгөөгөө танилцууллаа. Энэ үеэр малчид фермерүүд Монгол орныг хамарсан сүү бэлтгэн нийлүүлэх тогтолцоог бий болгож, малчид фермерүүд нь малынхаа сүүг үндэсний үйлдвэрүүдэд зах зээлийн ханшаар нийлүүлэх, үндэсний үйлдвэрүүд нь эх орны түүхий эдээр хямд өртөгтэй жинхэнэ органик бүтээгдэхүүнээр дотоодын хэрэглэгчдийг хангах улмаар экспортод гаргах, нэг талаас хэрэглэгчдэд эх орны түүхий эдээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн хэрэглэх боломжоо олгож буй ба нөгөө талаас дотоодын фермерүүд болон малчдын сүүг зах зээлийн ханшаар худалдан авах, малчид, фермерүүд маань сүүгээ борлуулах гэж санаа зовох шаардлагагүй, үйлдвэрүүд нь гадны улсаас өндөр үнэтэй түүхий эд зөөхгүй гэх мэт олон талын ач холбогдолтойг онцолж байлаа.

**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2405.00 | 2419.00 | ФУНТ | 3085.00 | 3179.00 |
| ЕВРО | 2673.00 | 2740.00 | РУБЛЬ | 42.00 | 44.10 |
| ИЕН | 21.46 | 21.77 | ЮАНЬ | 348.50 | 353.20 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2406.00 | 2422.00 | ФУНТ | 3094.00 | 3171.00 |
| ЕВРО | 2677.00 | 2745.00 | РУБЛЬ | 41.63 | 44.78 |
| ИЕН | 21.33 | 21.91 | ЮАНЬ | 348.50 | 351.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## МАН олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн улс төрийн хүчин болжээ

Г.ГАНАА

"Прогрессив Аллианс-Дэвшилтэт эвсэл" IV бага хурал өчигдөр Улаанбаатар хотноо боллоо. Бага хуралд Англи, Австри, Швед, Португали, Гүрж, Герман, Бельги, Малайз, Марокко, Судан, Энэтхэг, Израйль, Палестин зэрэг таван тивийн 34 улс, олон улсын байгууллагын төлөөлөл, улс төрийн намын удирдлагууд оролцов. Нийгмийн тогтвортой байдал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, Азийн орнуудын хөгжиж буй байдал, популизмын өсөлтийн нөлөөлөлтэй нийгэмд учруулах аюул, хүйсийн тэгш байдал, жендерийн асуудал зэрэг дэлхийн хэмжээнд тулгамдаж буй олон сорилт бэрхшээлд гарц шийдэл хайж, харилцан туршлага солилцсон өргөн хэмжээний чуулга уулзалт болсон юм.

"Прогрессив Аллианс"-ын ерөнхий зохицуулагч Константин Воинфф "Нэлээд өндөр түвшний зочид, төлөөлөгчид ирж оролцон бага хурал амжилттай боллоо. Энэ нь "Прогрессив Аллианс" монголчуудтай, МАН-тай эв санаа нэгтэй байгааг илэрхийлж буй хэрэг юм. МАН зөвхөн Монголд ч биш дэлхийн олон улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн улс төрийн хүчин болжээ" гэв.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# Б.Чойжилсүрэн: МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГТ НОГООН ГЭРЭЛ АСЛАА

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Энэхүү хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр Монгол Улс 5.5 тэрбум ам.долларын зээл авах эрх нь нээгдэх учиртай. Эдийн засгийн амаргүй цаг үед, төсвийн тодотголоо яаралтай хийж, алдагдлаа хангалттай хэмжээнд бууруулж, маш зоригтой шийдвэр гаргасан Монгол Улсын Засгийн газрыг үнэлж буйгаа Валютын сангийн суурин төлөөлөгч Нэйл Сакер онцолж байлаа. Тэгвэл Сангийн сайд Б.Чойжилсүрэн "Хөтөлбөр гурван жилийн хугацаатайгаар хэрэгжих бөгөөд нийт 5.5 тэрбум ам.долларын санхүүжилт орж ирнэ. Зөвхөн ОУВС гэхэд 434.3 сая ам.долларын санхүүжилтээр дэмжинэ. Эхний санхүүжилт болох 38.6 сая ам.доллар тун удахгүй орж ирнэ. Бусад түншүүд, тэр дундаа Азийн хөгжлийн Банк, Дэлхийн банк, Япон улс, БНСУ төсвийн болоод төслийн санхүүжилтээр дэмжлэг үзүүлэхээ амласан бол Хятадын Ардын банк Монголбанктай байгуулсан своп шугамын хугацааг сунгахыг зөвшөөрснөөр нийтдээ 5.5 тэрбум ам.долларын санхүүжилтийн багц бүрдэж байна" гэв. Өөрөөр хэлбэл, хөтөлбөрийн хүрээнд ОУВС-гаас 440 сая, Энэтхэгээс нэг тэрбум, Дэлхийн банкнаас 79 сая, Өмнөд Солонгосоос 500 сая ам.доллар мөн Польшоос 50 сая евро авах асуудал яригдаж байгаа аж. "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр" гурван жилийн хугацаатай хэрэгжих бөгөөд хөтөлбөрийн хүрээнд ОУВС-гаас олгох хөнгөлөлттэй зээлийн хүүг хөвөгч хүүгээр тооцох юм байна. Хөнгөлөлттэй зээлийн хүү хоёр хувиас хэтрэхгүй. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа 10 жил байх аж. Эргэн төлөлт тодорхой хуваарийн дагуу хийгдэх бөгөөд Монголд олгох 440 сая ам.доллараа нэг дор өгөхгүй гэдгийг ОУВС-гийн төлөөлөгчид онцоллоо. Хөтөлбөрийн гол зорилго нь эдийн засгийг сайжруулах, сэргээх, төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэгджээ.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Хөтөлбөрийн зорилтуудад нийцсэн төсвийн тодотгол УИХ-аар батлагдсан гэдгийг Сангийн сайд онцолж, эдийн засаг уналтаас өсөлт рүү шилжиж, ногоон гэрэл аслаа хэмээн тодотгов. Цаашид хөтөлбөрийн хэрэгжилтэд Валютын сантай хамтран улирал тутам үнэлгээ хийж ажиллах юм байна. Мөн эгзэгтэй цаг үед дэмжсэн Олон Улсын түншүүд болон, уужуу ухаан холч бодолтой, хүнд үед улсынхаа хөгжлийн төлөө хамтдаа зүтгэж буй иргэддээ Сангийн сайд талархал илэрхийлэв.

### Монголбанкны дансанд 38.6 сая ам.доллар орж иржээ

Тэгвэл эхний ээлжийн санхүүжилт болох 38.6 сая ам.доллар Монголбанкны дансанд өчигдөр орж ирснийг Төв банкны эх сурвалж мэдээлэв. Валютын сангийн зээлээр Төв банкны валютын нөөцийг нэмэгдүүлэх учиртай. Хэвлэлийн хурлын үеэр ОУВС-гийн Монгол дахь суурин төлөөлөгч Нэйл Сакер "Санхүүжилттэй холбоотойгоор бусад бүс нутгуудаас санхүүгийн дэмжлэг авч чадсан нь энэ хөтөлбөрийг батлахад дэмжлэг болсон. Нийт 5.5 тэрбум ам.долларын санхүүжилтийн дэмжлэг бүрдэнэ. Хувийн хэвшлээс оруулсан хөрөнгө оруулалттай нийлээд зургаан тэрбум ам.долларын санхүүжилт хийх юм. ДНБ-тэй нь харьцуулбал хамгийн том хөрөнгө оруулалт болж байгаа. Эдийн засгийг богино хугацаанд тогтворжуулж, урт хугацаандаа хүртээмжтэй, ажил эрхлэлтийг нэмэгдүүлсэн байх ёстой. Сүүлийн 15 жилд Монгол Улсын эдийн засагт ажиглагдсан өндөр зарлагыг таслан зогсоох явдал юм. Цаашдаа Монгол Улсын эдийн засгийг тогтвортой түвшинд найман хувийн өсөлттэй байхад хөтөлбөрийн зорилго оршиж байгаа" гэв. Хөтөлбөрийн нөхцөл хэдийгээр хүнд ч Монгол Улс амжилттай хэрэгжүүлж, эдийн засгийн тогтвортой бааз суурь бүрдүүлэх, улмаар төсвийн алдагдлыг бууруулж чадна гэж итгэж буйгаа энэ үеэр онцоллоо. Валютын сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-т хамрагдсанаар бид өрийн дарамтаас салж, Засгийн газар шат шатандаа хэмнэлтийн тогтолцоог бүрдүүлнэ гэж тооцжээ. Түүнчлэн, түүхий эдийн үнэ ханш сэргэх, ам.долларын ханш тогтворжих, төсвөө алдагдалгүй баталж сахилга баттай болох, орлого их хэмжээгээр төвлөрөх, мөн дотоодын санхүүгийн зах дээрх дарамтыг бууруулж, гадаад секторын үзүүлэлтүүдийг тогтворжуулан өрийн тогтвортой байдлыг сэргээнэ гэсэн хүлээлт буйгаа Сангийн сайд энэ үеэр онцоллоо. Хуралдааны дараа тэд сэтгүүлчдийн асуултад хариулсан юм.

**-Бусад орнуудад хэрэгжүүлсэн ОУВС-гийн хөтөлбөр амжилттүй хэрэгжсэн байдаг. Энэ талаар жишээ дурьдаж болох уу?**

**Нэйл Сакер:** -Улс орон бүр өөр өөрсдийн онцлогоор хөтөлбөрөө хэрэгжүүлдэг. ОУВС-гийн зүгээс эдийн засагтай холбоотой бүх асуудлыг нарийн судалдаг. Иж бүрэн тусгалаа олсон байдаг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байнга үнэлгээ хийж явдаг. Үнэлгээ хийх болгондоо эдийн засагт хийж байгаа өөрчлөлтийг тусгаж, холбогдох өөрчлөлтийг оруулаад явдаг. Үнэлгээ хийсэн даруй нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотой ОУВС-гаас зөвлөмж гаргадаг. Дэлхийн олон оронд хэрэгжсэн хөтөлбөрүүдийн тухайд Засгийн газрууд анх тохирсон ёсоороо хөтөлбөрийн бүрэн хэрэгжилтийг хангахгүй байсан. Монгол Улсын хувьд бид өөдрөг үзэлтэй байгаа. Монголбанкны валютын нөөц нэмэгдэнэ. Өнгөрсөн хугацаанд маш их хорогдсон. Нөөцийг нэмэгдүүлснээр эдийн засагт итгэх итгэл нэмэгдэнэ.

**-Засгийн газрын мөрийн хөтөлбөрт өөрчлөлт орох уу?**

**Б.Чойжилсүрэн:** Оруулах төлөвлөгөө алга. УИХ-ын сонгууль дөрвөн жилийн мөчлөгтэй, 48 сар байдаг. Бид ажил хүлээж аваад 10 сар орчим хугацаа өнгөрч байна. Эхний 18 сарыг бид эдийн засгийн уналтыг зогсоож, өсөлтийн суурийг тавих зорилт тавиад, тогтоол баталсан. Тэр хүрээнд ажил явж байна. Тиймээс өөрчлөлт орохгүй болов уу. 2017 оны хоёрдугаар хагасаас өсөлтийн суурийг бүрэн тавина гэж үзэж байгаа.

**-Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд банкуудад шалгалт хийсэн гэсэн. Үр дүн нь ямар гарсан бол. Хангалттүй гарсан банкууд олон байгаа гэсэн мэдээлэл бий?**

**О.Эрдэнэбилэг:** Хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй асуулт байна. Тогтвортой өсөлтийг бий болгох, орчныг бүрдүүлэхийн тулд эрүүл найдвартай, итгэлтэй санхүүгийн дэд бүтэц байх шаардлагатай. Тиймээс ОУВС-тай хэлэлцэж байгаад арилжааны банкуудад активийн үнэлгээ явуулсан. Тендерт саналаа ирүүлсэн банкуудаас богино жагсаалт гаргасан байгаа. Саналууд дээр ажиллаж байна. Зургадугаар сарын дундуур сонголтын процессыг дуусгаад, түүнээс хойш арилжааны банкуудад хөндлөнгийн актив хөрөнгийг үнэлдэг компаниудын мэргэжилтнүүдтэй ажиллана. Дүгнэлтээ 2017 оны аравдугаар сарын сүүлээр гаргана. Хоёрдугаарт, Монголбанкны хяналт шалгалттай холбоотой асуулт гарлаа. Системийн үнэлгээг харвал өөрийн хөрөнгийн хэрэгцээ 12 хувь байхаас 18 хувьтай байна. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар 25 хувь байхаас 40 хувь байна. Банкны систем найдвартай, итгэлтэй эрүүл байна гэж харж байгаа.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Ц.Тувааны АН-ын генсекээр жинхэллээ

АН-ынхан өнгөрсөн хугацаанд намынхаа дүрэмд шинэчлэл өөрчлөлт хийж, ҮЗХ-г 380 гаруй хүний бүрэлдэхүүнтэй Үндэсний бодлогын хороо болгон өөрчилсөн билээ. Ингэхдээ гишүүдээ намынхаа дотоод сонгуулиар шалгаруулж, залуус, эмэгтэйчүүдийг квотыг ижил тэгш оруулж өгсөн нь гишүүдийнх нь талархлыг хүлээсэн үйл явдал болсон юм. АН фракцийн улс төр хийхгүй гэдгээ ҮБХ-ны гишүүдийг эрс шинэчилж, гишүүдийнхээ итгэл үнэмшлээр томилсноороо харуулсан.

Улмаар тавдугаар сарын 08-нд "Корпрэйт" зочид буудалд намынхаа наймдугаар Их хурлыг хуралдуулж, Үндэсний бодлогын хорооны гишүүдээ батламжилсан юм. Тэгвэл шинэ бүрэлдэхүүнтэй болсон АН-ын Үндэсний бодлогын хороо өчигдөр хуралдаж, бодлогын хорооны гишүүдийнхээ үнэмлэхийг гардууллаа. Хуралдаан 15.00 цагт Төрийн ордоны Их танхимд болсон юм. Хуралдаан хаалттай горимоор Төрийн ордонд болж, Ц.Тувааныг Ардчилсан намын ерөнхий нарийн бичгийн даргаар баталж, жинхэллээ. Уг хуралдаанаар мөн улс төрийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах, Бодлогын зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах журам боловсруулах ажлын хэсэг байгуулах, сонгуулийн штабын журам батлах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр болсон. ҮБХ-ны хуралдаан дугаар шилжих мөчид хаалттай үргэлжилж байлаа.

## Бичил уурхай эрхлэгчдийг төр бодлогоор дэмжинэ

Б.ӨНӨР

Монгол Улсын Засгийн газраас "Алт-2" үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх тогтоол батлаад байгаа билээ. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хэсгийг Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржоор ахлуулан байгуулсан юм. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр жилд олборлох алтны хэмжээг 2-3 тонноор тогтвортой нэмэгдүүлж, 2020 онд 25 тоннд хүргэх зорилт тавиад байгаа. Монголбанкны хамгийн сүүлийн үеийн мэдээллээр 2014 онд Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг 2.5 болгосноор алт олборлогчид ченжид бус Монголбанкинд алтаа тушаах нь эрс нэмэгдэж, 2016 оны оны сүүлийн мэдээгээр 18.3 тонн хүрч дээд амжилт тогтоогоод байгаа аж. Гар аргаар алт олборлогч иргэд ч Төв банкинд алтаа тушаах боломжтой бөгөөд алтыг нь граммаар хэмжиж, улмаар иргэний үнэмлэх, харилцах банкны данс байхад иргэдийн дансанд мөнгийг нь өдөртөө багтаагаад шилжүүлэх боломжтой гэнэ. Бичил уурхай эрхлэгчид болон гар аргаар алт олборлож буй иргэдийн хувьд зардлын хямдыг бодож, олборлосон газартаа ченж нарт алтаа хямд үнээр өгдөг нь нууц биш. Тэгвэл Монголбанк "Алт-2" хөтөлбөрийн хүрээнд орон нутагт салбараа байгуулж, сорьцийн лаборатори байгуулан иргэдийн гарт байгаа алтыг худалдан авахаар төлөвлөж, бэлтгэл ажлаа хангаж эхэлжээ. Одоогоор Төв аймгийн Заамар, Баянхонгор аймагт байгуулагдахаар төлөвлөгөө гараад байгааг Төв банкны эх сурвалж дуулгалаа. Ингэснээр бичил уурхайн эрхлэгчид буюу гар аргаар алт олборлож буй иргэд ченжийн гарт хямд үнээр өгөх, эс бөгөөс хууль бусаар хил давуулах гэж оролдон зөрчил гаргасан хэргээр алтаа улсын орлого болгох зэрэг бэрхшээлтэй асуудлаас ангижирна. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хэлбэрээр жилд дунджаар 33-59 тэрбум төгрөгийг улсын төсөвт оруулж, геологийн эрэл хайгуулын ажлын үр дүнд Монгол Улсын алтны бэлтгэгдсэн нөөцийг 100-150 тонноор нэмэгдүүлэх боломжтой гэж Засгийн газар үзэж байгаа билээ. Сорьцийн лаборатори байгуулахад ойролцоогоор 850 сая төгрөг орно гэсэн урьдчилсан тооцоо гарчээ. Сорьцийн лаборатори байгуулагдсанаар бичил уурхай эрхлэгчид хууль ёсны дагуу ченжид цэнгээр биш граммаар, өндөр үнээр алтаа өгөх сайхан мэдээ дуулдлаа.

## О.Баасанхүү: Хийрхэл хэрээс хэтэрлээ

Б.ЭРХЭС

УИХ-ын гишүүн О.Баасанхүү өчигдөр Төрийн ордонд албан өрөөндөө сэтгүүлчдэд мэдэгдэл хийлээ. Эрхэм гишүүний нэрийг ашиглан фэйсбүүк хуудсанд "Худалдаа хөгжлийн банк дампуурах нь" гэсэн утга бүхий мэдээлэл явсан учраас иймэрхүү мэдээлэл тараагүй гэдгээ мэдэгдэж, мөн өөрийнх нь нэр хүндэд халдаж худлаа мэдээлэл цацсан О.Баасанхүү гэсэн фэйсбүүк хуудсыг Тагнуулын байгууллагад шалгуулахаар болсноо мэдэгдлээ. Тэрбээр, "Миний нэрээр хуурамч хаяг нээсэн байна. Энэ хуудсаар Худалдаа хөгжлийн банк удахгүй дампуурах нь гэсэн мэдээлэл цацсан. Би иймэрхүү мэдээлэл өгөөгүй. Би МАН-ын бүлгийн хуралд суудаггүй. Гэтэл намайг тэнд суусан юм шиг бичсэн байна. Энэ асуудлыг Тагнуулын Ерөнхий газарт өгсөн. Энэ бол асар ноцтой зүйл. Олон улсын валютын сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-т манайх хамрагдахаар болсон. Би үүнийг 100 хувь дэмжихгүй байгаа. Хятадын Засгийн газартай хоёр тэрбум ам.долларын своп хэлцэл хийсэн өрөө ойрын хугацаанд төлөх ёстой. 580 сая ам.долларыг төлөх гэж чардайж байхад хоёр тэрбум бол маш хэцүү шүү. Бидэнд хоёр сонголт байсан 4.5 тэрбум ам.долларыг Хятадын Засгийн газраас зээлж, өрөндөө хоёр тэрбумыг нь суутгах нэг сонголт байлаа. Нөгөөх нь ОУВС-д орж Япон, Дэлхийн банк зэрэг улс орнуудаас гурван тэрбум төгрөг зээлж, хоёр тэрбумынхаа зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах хоёр сонголт байсан. Би тангараг өргөж ажиллаж буй гишүүний хувьд ард түмэнд таалагдахын тулд бус хэрэгтэй шийдвэр гаргах ёстой гэдэг үүднээс энэ шийдвэрийн талд зогссон юм. Үүнийг зогсоох зорилготой, эдийн засгийг савлуулах хүсэлтэй, банк санхүүгийн байгууллагын талаар иймэрхүү мэдээлэл гарч байгаад би хувьдаа харамсч байна. Сангийн сайд Б.Чойжилсүрэнгийн нэрээр өмнө нь гарсан. Одоо миний нэрээр тарааж байгаа нь зохион байгуулалттай үйл ажиллагаа гэж би хувьдаа бодож байна. Надад ганцхан хаяг байдаг. Баасанхүү Октябр гэдэг англи галигаар бичсэн хаяг. Kh-тэй хаяг. Бусад надад ямар ч хамаагүй. Сонгууль дөхөж байгаа энэ үед иймэрхүү зүйл гарч байгаад харамсч байна. Хийрхэл, балайрал хэрээс хэтэрлээ" хэмээлээ. Аливаа банк итгэлцэл дээр суурилдаг, бас бусдын хадгаламжид санхүү нь тогтож байдаг. Надад банкны нөхцөл байдал хүндэрсэн, дампуурсан гэсэн албан болон албан бус ямар ч мэдээлэл ирээгүй. Гэтэл албан бус мэдээлэлд миний нэрийг хавчуулж, нийгэмд замбараагүй байдал үүсгэж байгаад харамсч байна гэв.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ҮЗЭЛ БОДОЛ

# ХЭН, ЮУ ХЭЛЭВ



Н.ПУНЦАГБОЛД

### С.Баяр: Н.Энхбаярын ярилцлагыг үзсэн, хачин л юм билээ

Монгол Улсаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн вант улсад суугаа Элчин сайд Санжийн Баяр маш олон сэдвээр хэвлэлд ярилцлага өгсөн байна. Тэр дундаа Ерөнхийлөгчийн сонгууль болоод МАХН-ын дарга Н.Энхбаяртай холбоотой сэдвүүдээр өөрийн байр сууриа илэрхийлжээ. Тэрбээр “Надтай ярихаар Энхбаярыг, Энхбаяртай ярихаар намайг ёс юм шиг асуудаг болоод удлаа. Заримдаа ч залхмаар. Гэвч тодорхой асуусан учраас би тодорхой хариулъя. Хүмүүс над руу утасдаад “Энхбаяр таны тухай аймаар, аймаар юм ярьсан шүү” гэсэн. Би “Ам нээвэл...” нэвтрүүлэгт өгсөн ярилцлагыг нь Ютүүбээс татаж үзсэн. Хачин л юм билээ. Төрийн том сэнтийд сууж байсан хүн гэхээргүй арай л задгай зайдан ярьж байна билээ. Ганц Оюу толгойн гэрээ гэлтгүй, намайг дэмжиж дарга болгосон тухай, долоон сарын 1-ний хэрэг явдалд өөрөөс нь бусад бүх хүн буруутай тухай, 2009 оны Ерөнхийлөгчийн сонгууль намын удирдлагын уршгаас болж амжилтгүй болсон тухай гэхчилэн өөр олон хүнийг хамарсан, өөр олон сэдвийг хөндөөд байсан. Уур бухимдалтай, сэтгэл санааны хувьд ихээхэн тогтворгүй байсан учраас тэр үү, эсвэл ерөөс ингэж ярьдаг болсон юм уу, илэрхий худлаа, огт авцалдаагүй үг амнаас нь унаж байх юм. Жишээ нь, Оюу толгойд манай эзэмших хувийн тухай асуудал байна. Энхбаярын ярьснаар бол, тэр намайг дуудаад л, Монголын тал 51 хувьтай байна шүү, нөхөөр, гэж захиж анхааруулжээ. Тэгтэл Монголдоо хайргүй би бээр түүнийг хуурч мэхлэн 34 хувь болгосон гэж ойлгохоор. Гэтэл бид хоёрын хооронд ийм яриа огт болоогүй. Болох ч үндэсгүй. Үүнийг хоёр том дарга яриад шийддэг ч юм биш. Энэ асуудал яриагаар биш хуулиар зохицуулагддаг” хэмээн ярьжээ.

### Ц.Мөнх–Оргил: Хятад иргэд визтэй зорчино

Сүүлийн үед давхар иргэншилтэй холбоотой асуудал нэлээд анхаарал татаж эхэлсэн. Гадаадад төрсөн монгол хүүхдэд давхар иргэншил олгохоор яригдаад байгаа. Үүнийг дагаад Хятадын иргэд Монгол руу визгүй зорчино гэсэн явган мэдээлэл ч газар авсан. Тэгвэл энэ талаар Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил байр сууриа илэрхийлжээ. Тэрбээр “Монгол Улсын харьяатын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг ГХЯ-ны ТНБД Д.Даваасүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг боловсруулж байгаа. Хуулийн төслөөр удахгүй хэлэлцүүлэг зохион байгуулна, холбогдох хүмүүсийн саналыг тусгана. Үүний дараа УИХ-д өргөн барих юм. Хуулийн төсөлд суулгах өөрчлөлт нь зөвхөн Монгол аав, ээжтэй гадаадад төрсөн хүүхдэд хамаарах юм. Жишээ нь, АНУ-д Монгол аав, ээжтэй хүүхэд төрдөг. АНУ хөрсний зарчмаар буюу хуулиараа өөрийн иргэн болгочихдог. Гэтэл Монгол Улс давхар иргэншилтэй болгохыг зөвшөөрдөггүй учраас хуулиараа АНУ-ын иргэн болоод үлддэг юм. Ийм төрлийн маш олон тохиолдол бий. Өмнө нь ийм тохиолдол цөөхөн байсан. Яагаад гэвэл монголчууд ийм олноороо гадаадад ажиллаж амьдардаггүй байлаа. Өөрөөр бол давхар иргэншлийн асуудал Монгол Улсын хуулиар хаалттай байдаг. “Олон зуун мянган Хятад иргэн орж ирэх гээд байна” гэсэн мэдээлэл сошиалд цацагдсан. Түүнийг би уншсан. Гэхдээ энэ мэдээлэл худлаа. Энэ бол улс төрийн зорилготой бусдын анхаарлыг өөр зүйлд сарниулах гэсэн оролдлого. Давхар иргэншлийн эрхийг гадаад улсын иргэдэд өгөхгүй. Зөвхөн монгол аав, ээжтэй гадаадад төрсөн хүүхэд өгөхөөр хуулийн нэмэлт өөрчлөлтийг боловсруулж байгаа. Сошиалаар Хятад иргэдэд давхар иргэншил олгох гэж байна гэх мэтийн зүйл “сэвж” байна лээ. Тийм зүйл огт байхгүй. Миний мэдэхээр БНХАУ болон Казахстанд давхар иргэншлийг хуулиараа зөвшөөрдөггүй. Тэгэхээр Хятад улсын иргэн давхар иргэншил авах бололцоо байхгүй. Дээр нь бид тийм асуудлыг огт яриагүй. Хятад иргэн Монгол Улсад орж ирнэ. Гэхдээ орж ирэхдээ ном журмын дагуу виз аваад орж ирнэ. Энэ дэглэм өөрчлөгдөхгүй” хэмээн ярьжээ.

### Т.Аюурсайхан: Тухайн үед сайдаар ажиллаж байсан зарим хүнийг шалгуулна

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос ажлын хэсэг гаргаж, Монголбанкинд шалгалт хийсэн билээ. Шалгалтаар цөөнгүй зөрчил илэрсэн талаар мэдээлэл гарсан. Тэгвэл энэ талаар ажлын хэсгийг ахалсан УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан ярилцлага өгчээ. Тэрбээр “Монголбанкны алдагдал 2012 оноос эхэлж хуримтлагдсан байдаг. Жишээ нь, 2011 онд 179 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байсан бол 2012 оноос 280 тэрбумын алдагдалтай болсон юм билээ. Ингэж явсаар 2016 онд жилийн 1.6 их наяд болж нийт гурван их наяд төгрөгийн алдагдалтай болсон байна. Энэхүү алдагдлыг хуулиар төсвөөс хаадаг. Ингэхдээ Засгийн газар үнэт цаас гаргадаг. Татвар төлөгчдийн халааснаас гарна гэсэн үг. Ийм л нөхцөл байдал үүссэн. Ажлын хэсэг үүнийг нягтлаад юунаас болов гээд шалгаад үзэхээр “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”-тэй холбоотойг тогтоосон. Монголбанкны үйл ажиллагааг Төв банкны тухай хуулиар маш тодорхой заагаад өгчихсөн байдаг. Гэтэл хуульд заагаагүй арга хэмжээг хэрэгжүүлсэн, түүнээс давсан үйл ажиллагаа явуулсан, зөрчсөн, бодлогын уламжлалт бус арга хэмжээг явуулсан байгаа юм. Үүний нэг нь “Үнэ тогтворжуулах хөтөлбөр”. Хөтөлбөрийн хүрээнд 4.8 их наяд төгрөгийг зах зээлд маш бага хүүтэйгээр аж ахуйн нэгжүүдэд олгосон байдаг. Үүнээс 369 тэрбум төгрөгийг зориулалтын бусаар зарцуулсныг тогтоосон. Шатахууны компаниудад их хэмжээний хөнгөлттэй зээл олгохын зэрэгцээ тухайн үеийн валютын ханшаас 300 төгрөг хүртэлх доогуур ханшаар өгсөн байгаа юм. Үүний улмаас төрд 480 орчим тэрбум төгрөгийн хохирол учирсан. Тэдгээр хөтөлбөрийг харахад хэрэгжүүлэх ямар ч үндэслэлгүй байсан. Шатахуун дээр ярихад дэлхийн зах зээл дээрх нефтийн үнэ тогтмол буурч ирсэн байдаг. 2012-2016 онд гэхэд дөрөв дахин буурсан. Үүнтэй холбогдуулж Монгол Улс руу орж ирж байгаа шатахууны хилийн үнэ гурав дахин буурсан байдаг. Гэтэл шатахууны компаниуд нэг ч төгрөгөөр үнээ бууруулаагүй. Татварын албанаас авсан мэдээллээр шатахууны импортлогч компаниудын ашиг энэ хугацаанд гурав дахин нэмэгдсэн байх жишээтэй. Гэвч нөгөө талд нь төр их хэмжээгээр хохирчихсон. Их хэмжээний нийлүүлэлт хийчихээр валютын ханш огцом өсөөд төгрөгийн худалдан авах чадвар огцом суларчихсан. Гэтэл үүнийгээ засахын тулд валютын интервенц хийчихсэн. Өнгөрсөн хугацаанд нийт долоон тэрбум ам.долларын валютын интервенц хийсний уршгаар нөөцөө шавхчихсан байгаа юм. Үр дүнд нь зах зээлд маш олон эрсдэлийг бий болгосон. Нийт илүүдэл мөнгөө буцааж татахын тулд Төв банкны үнэт цаас гаргасан ч түүнийхээ хүүд маш их зарлага гаргасан. Үүнээс гадна своп, форвард хэлцлүүдийг өнгөрсөн хугацаанд арилжааны банкуудтай байгуулсан байдаг. Үүний алдагдал гэхэд 1.7 их наяд төгрөг байгаа. Уг нь своп, форвард хэлцлээс Монголбанк алдагдал хүлээх үндэслэлгүй. Тийм болохоор тухайн үед ажиллаж байсан зарим сайдуудыг шалгуулна” хэмээн ярьжээ.

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

## “МОНГОЛ УЛСЫН ПАСПОРТТАЙ ХЭН БҮХЭНД ЭЛЧИН САЙДЫН ЯАМ НЭЭЛТТЭЙ АЖИЛЛАХ ЁСТОЙ ШҮҮ”

Б.ТОГТОХ

УИХ-ын чуулганы өчигдрийн хуралдаанаар гурван асуудал хэлэлцэн баталлаа. Тодруулбал, Статистикийн салбарыг 2016-2020 онд хөгжүүлэх Үндэсний хөтөлбөрийн эцсийн хэлэлцүүлэг, Усан замын тээврийн тухай хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгчөөс УИХ-тай зөвшилцөхөөр оруулж ирсэн зургаан Элчин сайдын асуудлыг эцэслэн хэлэлцэв. Хуралдааны эхэнд хэлэлцэх асуудлын дараалллыг батлах үеэр гишүүд хэлэлцэх асуудалд багтаагүй Элчин сайдын асуудал яагаад орж ирснийг тодруулав. Мөн Эрүүгийн хуульд хар тамхитай холбоотой заалтыг хассан гэх мэдээлэл хийсэн талаар Хуульзүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, гишүүдтэйгээ нийлж дайрч доромжилж байгаа нь хэрээс хэтэрлээ хэмээн О.Баасанхүү гишүүн бухимдсан юм. Хэлэлцэх асуудлын дараалалд ороогүй элчин сайдуудын томилгооны асуудлаар Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил “УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгч гадаад улсад суух элчин сайд, бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг УИХ-д зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо долоо хоногийн дотор хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана” гэсний дагуу асуудлыг оруулж ирсэн” гэж хариулав. Хуралдаанаар хэлэлцсэн Статистикийн байгууллагыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн тухайд гишүүд тун оновчтой санал хэлсэн. Өөрөөр хэлбэл, статистикийн байгууллагын тоо баримт Монгол Улсын хувь заяаг хаашаа ч эргүүлж мэдэх учраас тоо баримт аль нэг улс төрийн хүчин, нам эвслээс үл хамааран бодиттой байх ёстойг сануулллаа. Ингээд хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжиж эцэслэн баталлаа. Мөн энэ өдрийн хуралдаанаар хэлэлцсэн Усан зам тээврийн тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг мөн гишүүдийн олонхи дэмжиж, баталлаа.

### Улстөржиж ажиллах аваас эгүүлэн татна гэдгийг сануулъя

Энэ үгийг УИХ-ын олон гишүүд Элчин сайдуудад захиж байлаа. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Ерөнхийлөгч Швейцарь, Франц, Герман улсад суух Элчин сайдуудыг эгүүлэн татаж нэр бүхий гурван хүн томилох, мөн Япон, АНУ, Канадад суух Элчин сайдуудыг томилох асуудлыг УИХ-тай зөвшилцөхөөр оруулж ирсний дагуу томилогдох зургаан хүнээс гишүүд асуулт асууж, мөн санал хэлж байлаа. Тухайлбал, УИХ-ын гишүүн М.Оюунчимэг “Элчин сайдууд хэтэрхий хайнга ажилладаг. Зөвхөн гадаад өндөр дээд хэмжээний айлчлалыг өнгөрүүлэх гэж ажилладаг нь худлаа биш. Ер нь дипломат албаны нэр хүнд чухал шүү. Эхнээсээ жагсаал цуглаан хийж байна. Тиймээс иргэддээ хүрч ажиллаж, мөн эдийн засгийн том хэмжээний хөрөнгө оруулалт татах талаар хичээж ажиллаарай” гэв. УИХ-ын гишүүн Я.Санжмятав “Монгол Улсын гадаад паспорт өвөртөлсөн хэн бүхэнд Элчин сайдын яам үүдээ нээдэг байх ёстой”-г санууллаа. Д.Сумъяабазар гишүүн “Элчин сайдын яам утсаа авдаггүй гэх мэт хүнд суртал их байдаг. Өөр намын хүнтэй уулзахгүй гэх мэтээр улстөржсөн байдлаар асуудалд ханддаг шүү. Тийм зүйл гаргавал эгүүлж татна гэдгийг хатуу сануулъя” гэв.

Үүний дараа Элчин сайдуудад нэр дэвшигчийг товч танилцууллаа. Швейцарь улсад суух Элчин сайд Л.Пүрэвсүрэн нь 1964 онд Говь-Алтай аймагт төрсөн. 1984-1989 онд Москвагийн Олон улсын харилцааны дээд сургуулийг төгссөн, Олон улсын харилцааны мэргэжилтэй. ХБНГУ, Шинэ Зеланд, АНУ-д мэргэжил дээшлүүлсэн, орос, англи, герман хэлний мэдлэгтэй. Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд дипломат цолтой, дипломатын албанд 28 жил ажилласан байна. Франц улсад суух Элчин сайд А.Баттөр нь 1965 онд Ховд аймагт төрсөн. 1989 онд Москвагийн Олон улсын харилцааны дээд сургууль, 1995 онд Францын Үндэсний удирдлагын их сургууль, 2001 онд Шинэ Зеландын Виктория их сургууль, 2010 онд Бельгийн Вант Улсын Брюссель хот дахь Европын Стратеги, олон улсын харилцааны төвд мэргэжил дээшлүүлсэн. Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд дипломат цолтой, дипломат албанд 16 жил ажилласан аж. Герман улсад суух Элчин сайд Д.Ганбат 1962 онд Улаанбаатар хотод төрсөн. 1984 онд ЗХУ-д (хуучнаар) Уралын улсын их сургууль, 1987 онд МУИС-ийг төгсч, ХБНГУ, АНУ, Италид мэргэжил дээшлүүлсэн, орос, англи, герман хэлний мэдлэгтэй, төрийн албанд 33 жил ажиллажээ. Япон улсад суух Элчин сайд Г.Тэнгэр 1974 онд Улаанбаатар хотод төрсөн. 1994 онд Токио хотын Гадаад хэлний сургууль, 1998 онд Япон улсын Ёкохамагийн Үндэсний дээд сургууль, 2016 онд МУИС-ийн Нийгмийн ухааны сургуулийг төгссөн. Англи, япон хэлний мэдлэгтэй, төрийн албанд есөн жил, дипломат албанд нэг жил ажилласан байна. АНУ-д суух Элчин сайд Ё.Отгонбаяр 1965 онд Улаанбаатар хотод төрсөн. 1989 онд Москвагийн Олон улсын харилцааны дээд сургууль, 1995 онд БНЭУ-д Маркетинг менежментийн сургууль, 2000 онд ОХУ-д Дипломатын академийг төгссөн. Орос, англи, хинди, урду, франц хэлний мэдлэгтэй, “Тэргүүн шадар” дипломат цолтой, дипломат албанд 13 жил ажиллажээ. Канад улсад суух Элчин сайд Н.Чимгүүндарь 1983 онд Улаанбаатар хотод төрсөн. 2006 онд Москвагийн Олон улсын харилцааны дээд сургууль, 2016 онд Францын Үндэсний удирдлагын их сургууль төгсч, Нидерландын Клингендалийн их сургуульд олон улсын харилцааны чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн. Франц, орос, англи хэлний мэдлэгтэй, “Тэргүүн итгэмжит” дипломат цолтой, дипломат албанд 11 жил ажилласан байна. Ингээд хүн тус бүрээр санал хураалт явуулахад хамгийн бага саналыг Л.Пүрэвсүрэн нэр дэвшигч авч, хамгийн өндөр буюу гишүүдийн 100 хувийн саналыг Ё.Отгонбаяр авсан юм. Зургаан нэр дэвшигчийг дэмжсэн УИХ-ын тогтоолыг Ерөнхийлөгчид албан бичгээр илгээхээр тогтлоо. Хуралдааны төгсгөлд АН-ын гишүүн Ж.Батзандан үдээс хойш АН-ын ҮБХ-ны хурал хуралдаж, намын чухал асуудал хэлэлцэх учраас чуулганыг хойшлуулах хүсэлт гаргасан юм. Хоёр намын бүлэг зөвшилцөлд хүрсэн учраас УИХ-ын дарга чуулганыг өнөөдрийн 10.00 цаг хүртэл хойшлууллаа.

Дугаарын 60 мөр

### Хоцрогдсон баярын “амтгүй цэс”-ээ больчихооч

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь 1 нүүрт**

Хонхны баярын өглөө сургуулийн үүдэнд нэгдсэн журмаар нээлт хийж, захирал болоод уригдсан албаны хүмүүс үг хэлээд сурлага, урлаг, спортоороо тэргүүлсэн хүүхдүүдэд шагнал гардуулдаг. Дараа нь нээлттэй хичээлд орно. Ингээд аав ээж, найзууд, багштайгаа, ангиараа гээд хэд хэдэн зураг татуулах нь энэ өдрийн гол үйл явдал гэлтэй. Өглөөнөөс үд хүртэл иймэрхүү маягаар бужигнаж байгаад баярын цайллагадаа орохын тулд Зайсан толгой, Д.Сүхбаатарын талбай, Гандан гэдэг чиглэлээр замын түгжрэл үүсгэн сүр дуулиантай зорчино. Олон сургууль нэгэн зэрэг хонхны баяр хийж байвал төдий чинээ замын хөдөлгөөн түгжрэх нь ойлгомжтой. Уг нь хүүхдүүд Зайсан толгой, Д.Сүхбаатарын талбайн хаана юу байдгийг андахгүй мэднэ. Гандангаар ч жилдээ 1-2 удаа орчихдог. Гэтэл хонхны баяраар заавал ийм чиглэлээр зорчихын хэрэг юун. Энэхүү маршрутаар ангиараа автобусанд сууж зорчоод, хамтдаа зоог барьсанаа хожим хойно нь хонхны баярын дурсамжтай үйл явдлаар нэрлэдэг нэг ч төгсөгч байхгүй. Нэг ч шинэ зүйл байхгүй, ямар ч өөр мэдрэмж төрөөгүй зүйлийг хэн дурсах вэ дээ. “Би хонхны баяраараа автобусанд сууж Зайсан толгой орж зургаа авахуулсан. Тэгээд Д.Сүхбаатарын талбай, дараа нь Гандангаар орж хийморио сэргээж билээ” гээд хэн нэг нь дурсч суувал хүүхэд нохойн доог болохоос биш “Энэ хүн хонхны баяраа дурсамж дүүрэн тэмдэглэсэн юм байна шүү дээ” гэдэг сэтгэгдэл огтхон ч төрөхгүй. Хонхны баярыг хоцрогдсон аргаар “амтгүй цэс”-ээр хачирлан тэмдэглэдэг учраас тэр. Тэгээд ямар ч шинэ орц үгүй атал зарцуулах мөнгө нь жилээс жилд өсч хүүхэд, эцэг эхийг зөрчилдүүлдэг. Боломжтой айлын хүүхдүүдэд бол өнгө мөнгөө гайхуулах сайхан далим шалтаг. Бололцоогүй айлын хүүхдэд нүүрээ хийх ч газар олдохгүй гутамшигт өдөр болж хувирчээ, хонхны баяр.

Саяхан “Их засаг” их сургуулийн харьяа лицейн төгсөгчид өндөр үнэтэй, тансаг зэрэглэлийн машины цуваа үүсгэсэн. Энэ нь олны нүдийг бүлтийлгэж, чихийг дэлдийлгэсэн үйл явдал болсон гэхээсээ илүүтэй “баян, ядуугийн ялгааг харууллаа” гэдэг дургүйцлийг нийгэмд төрүүлэв. Тэд үүнээс өөрөөр чухам яаж хонхны баяраа тэмдэглэж ямар дурсамжтай үлдсэнийг мэдэхгүй. Гэхдээ ерөнхий хөтөлбөр нь бусадтайгаа ижилхэн, магадгүй хувцас хунар, гоёл чимэглэлдээ чамлахааргүй хэдэн төгрөг зарцуулсан болов уу. Хонхны баяраар далимдуулан цуглуулсан фондны мөнгө ихэвчлэн анги засвар, багшийн бэлэг, ууж идэхэд л зарцуулагддаг. Дээрээс нь хувцас хунар, гоёл чимэглэл авна. Бусдын дор орохгүй гэсэндээ цаг зав гаргаж, мөнгө төгрөгөө зарцуулан байж авсан хувцас гоёлоо хэр удаан өмсч зүүдэг бол. Зарим охидын гоёл ганцхан удаа буюу хонхны баярын үдэшлэгт өмсөөд л шүүгээний буланд мартагдаж орхидог нь нууц биш. Хайран мөнгө, хайран цаг хугацаа. Бүтэн жил ярьж, хүсч мөрөөдөж байж тэмдэглэсэн хонхны баяр нь нэг иймэрхүү.

Хүн болгон ухаалаг утастай, түүгээрээ хүссэн үедээ ямар ч зураг дараад угаалгадаг болсон өнөө цагт ангиараа болон найз нөхөдтэйгээ зураг авахуулахын тулд хэт өндөр зардал гарган бүхэл бүтэн өдрийг зарцуулахын хэрэг юун. Аав ээж, ах дүү нартайгаа гээд гэр бүлийн зургийн тухайд Цагаан сар, наадам зэрэг монголчуудын хувьд нэг гэр бүл байтугай ураг төрлөөрөө цуглардаг баяр олон. Харин хонхны баяраараа нийгэмд тустай сайн үйлсийн аян, эсвэл юу сурсан мэдсэнээ жинхэнэ утгаар нь тайлагнасан шиг тайлагнаж, ёстой “бут аваад” өгдөг болвол ямар вэ.

# ДЭЛХИЙ

## "WannaCry" вирус нэг тэрбум ам.долларын хохирол учруулжээ

Саяхан гарсан "WannaCry" вирусийг ашиглаж, Windows үйлдлийн системтэй компьютеруудыг онилон хийсэн өргөн хүрээтэй кибер халдлагын улмаас учирсан хохирлын хэмжээ нэг тэрбум ам.доллароос давжээ. Энэ тухай McClatchy мэдээллийн алба Америкийн шинжээчдийн дүгнэлтийг иш татан мэдээлсэн байна. Мэдээлэлд дурдсанаар, тавдугаар сарын 12-нд эхэлсэн кибер халдлагын улмаас долоо хоног хүрэхгүй хугацаанд 150 гаруй орны 300 мянга орчим компьютер вирустжээ. Цаашид ч хакеруудын зүгээс ийм халдлага хийнэ гэдгийг Америкийн мэргэжилтнүүд үгүйсгэхгүй байгаа юм.

"KnowBe4" компанийн захирал Стью Сьюверманы хэлснээр "WannaCry" вирус тархсанаас хойш дөрвөн өдөрт учирсан хохирол нэг тэрбум ам.долларыг давжээ. Тухайн үед дэлхий даяарх томоохон компаниудын үйлдвэрлэл бараг зогссон учир урьдчилсан тооцоолоход л дээрх тооны хохирлын хэмжээ гарч байгаа аж. Үйлдвэрлэлтийн хэмжээ буурсан, байгууллагын ажил доголдож, шүүхийн магадлан шинжилгээ хийхэд тодорхой зардал гарсан, компанийн бизнесийн нэр хүндэд хохирол учирсан зэрэг гарз хохирлыг тэрбээр дурдсан байна."Shadow Brokers" нууц нэрийн дор үйл ажиллагаагаа явуулдаг бүлэг хакерууд өнгөрсөн онд хакерын халдлага үйлдэхэд ашиглах программ хангамжийг боловсруулжээ. Уг программ хангамжийг АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын агентлаг зохиосон гэж хакерууд ярьсан гэнэ. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар, уг программд хэд хэдэн удаа сайжруулалт хийсний дараа "WannaCry" вирус гарч иржээ. Тавдугаар сарын 12-нд хакерууд вирусийн тусламжтайгаар дэлхий даяар халдлага үйлдсэн билээ. Вирусээр халдварлагдсан компьютеруудын түгжээг гаргахын тулд хакерууд 600 ам.долларыг "Bitcoin" гэдэг цахим мөнгөөр шилжүүлэхийг шаардаж, төлбөрийг хийгээгүй тохиолдолд компьютерын хатуу дискэнд байгаа мэдээллүүдийг бүгдийг нь устгана гэж заналхийлсэн байдаг. Америкийн шинжээчдийн тооцоолсноор, хакерууд хохирогчдоос нийтдээ 116500 ам.доллар авсан аж.

## МАНЧЕСТЕРЫН ХАЛДЛАГЫН НУУЦ МЭДЭЭЛЛИЙГ АНУ-Д ЗАДРУУЛСАН УУ

Б.ДАВАА




Их Британийн Манчестер хотод байрлах "Манчестер Арена"концертынтанхимдорон нутгийн цагаар энэ сарын 23-ны орой 21.33 цагийн үед томоохон хэмжээний дэлбэрэлт болсон. Тухайн үед залуу дуучин Арена Грандегийн аялан тоглолт болж байсан юм. Гэвч харамсалтай нь дэлбэрэлтийн улмаас 22 хүн нас барж, 50 гаруй хүн шархдан эмнэлэгт хүргэгдсэн байна. Дуучин бүсгүйн хувьд ноцтой гэмтэж бэртээгүй ч, болсон явдалд харамсан гашуудаж буйгаа нийгмийн сүлжээгээр илэрхийлэн, мөн аялан тоглолтоо цуцалж буйгаа мэдэгдсэн удаатай.

Тус террорист халдлагыг хэт даврагч "Лалын улс" бүлэглэлийн гишүүн болох ливийн цагаач иргэн үйлдсэн нь эдүгээ ил болоод байгаа юм. Халдлага үйлдэгч амиа золиослосон байдаг. Одоогоор хэргийг хууль хяналтын байгууллага шалгаж байгаа. Тэгвэл тус хэргийн мөрдөн шалгалтын талаарх нууц мэдээлэл АНУ-ын талд алдагдсан тухай өчигдөр орон нутгийн зарим хэвлэл дамжууллаа. Тодруулбал, өчигдөр Манчестер хотын цагдаагийн газраас мэдэгдэл хийж, хэргийн мөрдөн шалгалттай холбоотой нууц мэдээллийг хэд хэдэн удаа задруулсан тохиолдол гарсан тухай мэдээлжээ. Улмаар ийнхүү мэдээлэл нууц байдлаа алдах нь мөрдөн шалгах ажиллагаанд ноцтой хохирол учруулж байгааг онцолсон байна. "Би Би Си" агентлагийн мэдээснээр тус улсын цагдаагийн байгууллага АНУ-ын холбогдох албатай мэдээлэл солилцох ажиллагаагаа зогсоосон аж.

Их Британийн Терроризмтой тэмцэх албаны төлөөлөгч хэвлэлийн хурлын үеэр мөрдөгчдийн хамтын ажиллагаа дэлхий нийтийн аюулгүй байдал, итгэлцэл дээр үндэслэдэг гэдгийг онцлоод "Тэрхүү итгэлцэл нуран унасан тохиолдолд хамтын ажиллагаа ч доголдож, бидний ажлын гол хөшүүрэг болох хохирогч, гэрч, тэдний гэр бүлийнхэний итгэл алдрах болно" хэмээжээ.

Мөн "Томоохон хэмжээний терроризмын эсрэг мөрдөн шалгалт хийх явцад нотлох баримт болох зүйлийг зөвшөөрөлгүйгээр нийтэд задруулсан тохиолдолд үр дагавар нь асар хор хохиролтой" гэдгийг онцолсон байна.

"Би Би Си" агентлагийн тухайд Их Британи АНУ-ын цагдаагийн холбогдох байгууллагатай мэдээлэл солилцох үйл явцыг хориглосон гэдгийг мэдээлсэн. Гэхдээ үүний шалтгааныг АНУ-ын Тагнуулынхан тус террорист ажиллагаатай холбоотой зарим мэдээллийг задруулсантай холбоотой" гэж тайлбарлажээ.

Нөгөөтэйгүүр, цагдаагийнхан энэ хэрэгтэй холбогдуулан Манчестер хотын орчмоос хоёр эрэгтэйг баривчилжээ. Өмнө нь нэг эмэгтэйг баривчилсан гэх мэдээлэл байсан ч, халдлагатай холбоотой гэх нотлох баримт олдоогүй учир сулласан аж. Хамгийн сүүлд авсан мэдээллээр нийтдээ найман хүн баривчлагдаад байна.

## Зэвэрсэн "Севол" хөлгөөс гурав дахь хүний цогцос олдлоо

БНСУ-ын Далайн загас агнуурын яамнаас өчигдөр хэвлэлийн хурал зарлажээ. Энэ үеэр эх газарт чирч гаргасан Севол хөлөг дотроос хамгийн сүүлд нэг хүний араг ясны хэлтэрхий олдсон нь ор сураггүй болсонд тооцогдож буй хүмүүсийнх нэгийнх болохыг тогтоосон тухай мэдээлсэн байна. 2014 оны дөрөвдүгээр сарын 16-нд БНСУ-ын Чэжү арлыг чиглэн хөвж явсан "Севол" гатлага онгоц Чендо гэх арлын орчимд живсэн билээ. Ослын улмаас 300 гаруй хүн амь үрэгдсэн бөгөөд эдүгээ ч гэсэн есөн хүн ор сураггүй болсонд тооцогдож байсан юм. Харин живсэн "Севол" хөлөг хүн бүрийн нүдний өмнө далайн усанд гурван жил хэвтэж, ор сураггүй болсонд тооцогдож буй хохирогчдын ар гэрийнхэн талийгаачдынхаа цогцсыг олж, хүний ёсоор эцсийн замд нь үдэх хүслэн болсоор байжээ. Улмаар эцэст нь энэ оны гуравдугаар сард хөлөг онгоцыг боомт руу чирч гаргасан бөгөөд түүнээс хойш ор сураггүй болсон иргэдийн цогцсыг хайх ажиллагаа эхлээд байжээ. Тэгвэл албаны эх сурвалжийн өгсөн мэдээллээр, хөлгөөс гурван өөр хүний араг ясны хэлтэрхийг олж, ор сураггүй болсонд тооцогдож байсан хохирогчдынх болохыг нь тогтоожээ. Хамгийн сүүлд "Данвон" ахлах сургуульд суралцаж байсан Чо Юн Ва гэх охины цогцсыг олсон байна. Охин хөлөг осолдох үед 17 настай байсан юм. Үүнээс өмнө Ко Чан Сок гэх багш болон өөр нэгэн эмэгтэй сурагчийн цогцсыг олж илрүүлээд байжээ. Одоо тус ослоос зургаан хүн ор сураггүй болсонд тооцогдож байна.

## Хятадын хоёр ажилтан хулгайлагджээ

Пакистаны баруун өмнөд этгээдийн Балочистан мужийн нийслэл Күэттагаас өдрийн цагаар тухайн бүс нутагт ажиллаж байсан БНХАУ-ын хоёр иргэнийг хулгайлсан хэрэг гарчээ. Хэрэг энэ сарын 24-ний өдрийн үд дундын үед гарсан байна. Күэтта нь 50 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй "Хятад-Пакистаны эдийн засгийн коридор байгуулах гол бүс нутагт багтдаг. Гэвч, Пакистанаас салан тусгаарлахыг хүсдэг зэвсэгт бүлэглэл, хэт даврагч байгууллага террорист ажиллагаа явуулсаар байгаа бөгөөд энэ удаагийн хэргийн улмаас аюулгүй байдлаа чангатгаж эхэлжээ.



Албаны эх сурвалж "Франц пресс" агентлагт "БНХАУ-ын иргэн болох эрэгтэй, эмэгтэй хоёр хүн Күэтта мужийн Жиннагаас хулгайлагдсан" гэж ярьжээ. Тэднийг үл таних гурван этгээд улсын дугааргүй автомашинд хүчээр суулган авч явсан байна. Тухайн үед эмэгтэй нь зугтахыг оролдсон ч, гэмт этгээдүүд буу тулган сүрдүүлсэн аж. Мөн тухайн хэргийг хараад, зогсоохыг оролдсон нэг хүн халдлагад өртсөн байна.

Одоогоор нийслэл Исламабад хот дахь Хятадын Консулын газраас мэдэгдэл хийж, хулгайлагдсан хятад иргэдийг даруй суллахыг шаарджээ. Хохирогчид орон нутгийн хэлний сургуульд урду хэл сурч байжээ. Харин цагдаагийнхан тэднийг Хятад хэлний багш нар байсан тухай мэдээлсэн байдаг.

## ХӨӨТ-БИЧИГТИЙН ТӨМӨР ЗАМЫН АЖИЛ ИРЭХ САРД ЭХЛЭХ НЬ

Г.ГАНЧИМЭГ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Зам, тээврийн салбарт хэрэгжиж буй бодлого, үйл ажиллагаа, томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үйл явцыг танилцуулсан нээлттэй хаалганы өдөрлөг өнгөрсөн хоёр хоногийн турш Төв талбайд дэлгэгдэж өндөрлөлөө. Талбайн хойморт зассан асарт "Монголын төмөр зам" компанийнхан танилцуулга хийж байхыг сонирхсон юм. "Монголын төмөр зам" ТӨХК нь төмөр замын салбарт улсын төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр үүссэн өмчийг эзэмших, ашиглах, бизнесийн шударга өрсөлдөөнийг бий болгох, төмөр замын салбарт үндэсний компани бий болгох зорилгоор 2008 онд байгуулагдсан гэдгийг уншигчид маань санаж буй байх.

Хамгийн гол нь УИХ-аас 2010 онд "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ыг баталж, Монгол Улсад 5600 орчим км төмөр замын суурь бүтцийг гурван үе шаттай барихаар шийдсэн. Энэхүү ажлыг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоолоор эхний нэг, хоёрдугаар үе шатанд барих төмөр замын суурь бүтцийг улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын суурь бүтэц гэж үзэж, хэрэгжүүлэх тусгай зөвшөөрлийг "Монголын төмөр зам"-д олгосон юм. Улмаар энэ ажил ямархуу төвшинд яаж явж буйг иргэд их сонирхдог. Одоогоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь угсралтын ажил 52 хувийн гүйцэтгэлтэй яваа аж. Харин бусад чиглэлийн төмөр замын техникийн зураг төсөл болон хээрийн судалгаа, урьдчилсан ТЭЗҮ-г хийж дуусчээ.



"Монголын төмөр зам"-ын гүйцэтгэх захирал Х.Хэрлэн "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан Тавантолгой-Гашуунсухайт, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулах, Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замаас Оюутолгойн салбар төмөр зам, Шивээ хүрэн-Сэхэ чиглэлийн боомтын төмөр замыг барьж дуусгах, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Энэхүү бүтээн байгуулалтынажлынхүрээндбид Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ТЭЗҮ-ийг боловсруулсан. Ирэх сарын дундуур төмөр замын ажлыг эхлэх төлөвлөгөөтэй" байгаагаа танилцуулав.

Мөн БНХАУ-ын Тяньжин хотын "Дунзяны гаалийн баталгаат боомт" бүсэд 10 га газрыг 50 жилийн хугацаатай эзэмшиж, БНХАУ-ын талтай хамтарсан тээвэр ложистикийн төв байгуулахаар ажиллаж буй аж. Энэхүү төслийг хэрэгжүүлэх давуу эрхийг "Монголын төмөр зам"д олгожээ. Тус төсөл дээр хамтран ажиллах сонирхол бүхий хувийн аж ахуйн нэгжүүдийг сонгох, хэлэлцээ хийх, төслийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхээр ажиллаж буй юм байна. Тус төсөл хэрэгжсэнээр Тяньжин боомтод Ази, Европыг холбосон ложистикийн нэгдсэн систем бий болж, уул уурхай, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг экспортлох, экспорт, импортын тээвэрлэлтийн хугацаа, зардлыг бууруулах, өргөн хэрэглээний импортын зарим хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, чөлөөт бүсийн хөнгөлөлттэй орчинд дотоодын аж ахуйн нэгжүүдийг үйлдвэрлэл, бизнес эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх зэргээрээ ач холбогдолтой юм.

"Монголын төмөр зам" төмөр замын ачаа тээвэрт зохих үүрэгтэй оролцож байгаа төдийгүй Сэлэнгэ аймаг дахь өөрийн эзэмшлийн Төмөртэйн төмөр замаар өнгөрсөн онд нэг сая тонн ачаа тээвэрлэсэн. Харин энэ онд 1.5 сая тонн ачаа тээвэрлэхээр дотоод нөөц боломжоо дайчлан ажиллаж байгаа гэдгээ тус компанийн ажилчид танилцуулж байлаа.

Одоогоор "Улаанбаатар төмөр зам"-тай хамтран өөрийн эзэмшлийн 245 ачааны вагон, долоон зүтгүүртэйгээр ачаа тээврийн үйл ажиллагаа явуулж буй аж.

MMINFO.

# СПОРТ



“МАНЧЕСТЕР ЮНАЙТЕД” ЕВРОПА ЛИГТ АНХ УДАА ТҮРҮҮЛЖ, АВАРГУУДЫН ЛИГИЙН ЭРХЭЭ АВЛАА

VII нүүр

НИКИ ХЕЙДЕН ЭРХТНИЙ ДОНОР БОЛНО

VIII нүүр

АМЖИЛТЫН ЭЗЭН

## Номура Тадахиро:



## Айдас гэдэг ганцаардалтай хийх тэмцэл юм

Орчуулсан Б.ДАВААХҮҮ

Атланта, Сидней, Афин гэсэн гурван удаагийн олимпоос жүдо бөхийн төрөлд дараалан алтан медаль хүртсэн Японы алдарт тамирчин Номура Тадариогийн “meiko-community.jp” сайтад өгсөн ярилцлагыг орчуулан хүргэж байна. Тэрбээр эрэгтэйчүүдийн 60 кг-ын жинд барилдаж байсан бөгөөд энэхүү ярилцлагад өөрийн амьдрал хийгээд спортын туршлага, гэмтэл бэртлийнхээ талаар сонирхолтой яриа өрнүүлжээ.

**Төгсгөл нь VII нүүрт**

## 2020 оны жүдо бөхийн ААШТ Монголд болно

Азийн жүдо бөхийн холбооны удирдах зөвлөлийн хурал энэ сарын 24-нд Хонконгт боллоо. Энэ хуралд манай улсаас Азийн жүдо бөхийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн, Сахилгын хорооны дарга Б.Пагва, олимпын зэрэглэлийн шүүгч, МЖБХ-ны гүйцэтгэх захирал М.Бөхбат нар оролцсон. Тус хурлаар шийдвэрлэсэн гол асуудал нь 2020 оны Азийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах хотыг сонгох байлаа. 2017 оны ААШТ энэ сарын 26-28-нд Хонгконгт болох бол 2018 онд Азийн наадам Индонезийн Жакартад, 2019 оны Азийн аварга Саудын Арабт тус тус зохион байгуулагдах юм. Хуралд оролцогчдын шийдвэрээр Монгол Улс "Токио-2020" олимпын наадмын жил өөрийн эх орондоо тивийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах эрхийг авлаа. Ийнхүү тивийн шилдэг жүдочид Токиогийн олимпын жил Улаанбаатар хотноо өрсөлдөхөөр боллоо.

## Х.Амартүвшин Япон, М.Нандин-Эрдэнэ Бразилын тамирчинтай тулалдана

БНСУ-ын нийслэл Сөүл хотын "Jangchung" спортын ордонд холимог тулааны "Road FC" холбооны шилдэг 16 тамирчны хоёр дахь тулаан долдугаар сарын 15-нд болох тов гарлаа. Нэг сая ам.долларын шагналын сантай тус тэмцээнд манай тулаанч М.Нандин-Эрдэнэ, Х.Амартүвшин нар багтсан байгаа. Тэд эхний ялалтаа илт давуу байгуулсан бөгөөд дараагийн тулааны салхийг манай Х.Амартүвшин Японы тамирчин Сасаки Шинжитэй хагалах юм. Харин М.Нандин-Эрдэнэ маань Бразилын Тонихо Фүриатай тулалдахаар болов. Сонирхуулахад эхний тулаанд М.Нандин-Эрдэнэ өрсөлдөгчөө цэвэр ялсан бол Х.Амартүвшин маань урд хөршийн тамирчинд ердөө 55 секунд зарцуулсан билээ.

## Гар бөмбөгчид дөрөвдүгээр байрт шалгарлаа



Волейболын Зүүн Азийн аварга шалгаруулах тэмцээний хүрэл медалийн төлөөх тоглолт Буянт-Ухаа спорт цогцолборт өчигдөр болж, Монгол Улсын шигшээ баг дөрөвдүгээр байрт шалгарлаа. Хүрэл медалийн төлөөх тоглолтыг манай шигшээ багийнхан БНСУ-ын багтай хийсэн бөгөөд 3:0-ээр ялагдал хүлээв. Хэсгийн тоглолтод хоёр баг таарч, эн тэнцүүхэн тоглолт үзүүлэн, БНСУ-ын баг нэгээр харин манай баг хоёроор гарсан. 13.00 цагаас эхэлсэн тоглолтод 25:19, 25:20, 25:15 харьцаатайгаар өндөрлөлөө. Монголын эрэгтэйчүүдийн шигшээ баг Макаогийн багийг 3:0 хожиж, БНСУ-ын багт 2:3-р хожигдсон юм.

Харин өчигдөр Японы багтай учраа таарч хожигдсоноор хүрэл медалийн төлөө тоглохоор болсон. Хоёр жилийн өмнө 2015 онд Зүүн Азийн АШТ Улаанбаатар хотод болоход манай баг мөн л БНСУ-ын багтай хүрэл медалийн төлөө тоглож, хожигдож байв.

## Хакүхо Нацу башёг тэргүүлж эхэллээ

Японы мэргэжлийн сумо бөхийн тавдугаар сарын тэмцээн буюу Нацу башёгийн 12 дахь өдрөөс Их аварга Хакүхо М.Даваажаргал тэргүүлж эхэллээ. Тэрбээр Точиозанаар 12 дахв даваагаа авч нэг ч унаагүй тэргүүлж байна. Харин Их аварга Харүмафүжи Д.Бямбадорж 11 дэх өдрийн барилдаанд Комосүби Митакемидёорикири мэхээр унасны улмаас өнөөдрийн байдлаар 11 даваа, нэг унаатай болж тэргүүлэгчдийн хоёрдугаар эгнээнд бичигдэв. Озэки Тэрүнофүжи Г.Ган-Эрдэнэ 10 дахь даваагаа авч тэргүүлэгчдийн гуравдугаар эгнээнд үлдлээ. Аварга Кисэносатогийн тухайд башёг орхисон. Тэрбээр башёгийн эхний өдөр Ёошиказэд ялагдсан бөгөөд башёг зургаан даваа, дөрвөн унаатай өндөрлүүлэв. Аварга Кисэносато мөрөндөө авсан бэртлээ сайн эмчлүүлээд ирэх долдугаар сарын башёд ирэхээ амаллаа. Ийнхүү Нацу башёг монгол аваргууд тэргүүлж, Хакүхо 12, Харумафүжи 11, Тэрүнофүжи 10 даваатай явж байна.



## Ц.Батчулуун Шатрын дэлхийн цомын төлөө өрсөлдөнө

Олон улсын шатрын Их мастер Ц.Батчулуун шилдгийн шилдэг 128 шатарчдын дунд зохиогдох Шатрын дэлхийн цомын төлөөх тэмцээнд оролцох эрхийг Монгол Улсаас анх удаа авчээ. Тэрбээр БНХАУ-ын Ченгду хотод зохиогдсон “Насанд хүрэгчдийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн”-ий нээлттэй төрөлд шилдэг 33-н Их Мастеруудтай өрсөлдөж, эрхээ авсан бөгөөд энэ амжилт нь Монголын шатрын түүхэнд гарцаагүй цоо шинэ хуудсыг нэгээр нэмж байгаа хэрэг аж. Ц.Батчулууны хувьд 2011 онд их мастерын болзол хангасан бөгөөд шатрын спортоор 25 жил хичээллэж байгаа юм.

## П.Болдбаатар дэлхийн аваргаас мөнгөн медаль хүртлээ

Литви улсад пауэрлифтингийн хэрэглэлтэй төрлийн өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид, мастер ангиллын ДАШТ энэ сарын 22-нд эхэлсэн билээ. Тус тэмцээнд манай улсаас Монголын пауэрлифтингийн нэгдсэн холбооны найман тамирчин өрсөлдөж байгаа юм. Өчигдөр тэмцээний мастер-1 ангиллын +120 кг-ын жинд П.Болдбаатар 305 кг-ыг шахсанаар мөнгөн медаль авлаа. Энэ амжилт тус тэмцээнээс хүртсэн Монголын багийн анхны медаль юм. Түүнээс гадна энэ тэмцээнд өсвөр үеийнхний 66 кг-ын жинд С.Сүхбат, насанд хүрэгчдийн 74 кг-д Б.Баярбаатар, 83 кг-д Б.Гансүх, 93 кг-д М.Галсайхан, 105 кг-д Д.Түмэнжаргал, -120 кг-д Б.Чимэдцэрэн, Б.Алтангэрэл нар оролцож байгаа бол мастер-1 ангилалд П.Болдбаатар хүч үзэж байна. Тэмцээн маргааш өндөрлөнө.

ЗАР - ЗАР - ЗАР

**Төрөл бүрийн мод, бут, сөөг, мандлын цэцэг борлуулж байна. Мөн зүлэгжүүлэлт хийж өгнө.**

**Хасу мод компани** 94009909, 99191366

## Сэтгүүлчид спорт авиралтаар өрсөлдөнө

Монголын Үндэсний Олимпийн Хороо, Монголын Уулчдын Үндэсний Холбоо болон Монголын Спортын Сэтгүүлчдийн Холбоооноос хамтран зохион байгуулж буй сэтгүүлчдийн дундах Спорт авиралтын нээлттэй тэмцээнийг маргааш зохион байгуулах гэж байна. Монголын уулчдын холбооны URSA төвд болох энэхүү тэмцээнд хэвлэл, мэдээллийн байгууллагуудын төлөөлөл оролцох юм. “Авирагч сэтгүүлч” тэмцээний зорилго нь уулын спортын төрөл болох спорт авиралтын төрлийг олон нийтэд сурталчилах, Монголын спортын хэвлэл мэдээлэл, сэтгүүлч залуучуудын дунд Олимпизмийн үзэл санааг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх цаашдаа уулын спорт сонирхогч байгууллагуудтай хамтран ажиллах ажиллагааг идэвхижүүлэхэд оршино. Тэмцээний бэлтгэл сургуулилттай холбоотой асуудлыг 89893789 дугаараар холбогдож лавлах боломжтой ажээ.

# СПОРТ

FOOTBALL NEWS

## “МАНЧЕСТЕР ЮНАЙТЕД” Европа лигт анх удаа түрүүлж, АВАРГУУДЫН ЛИГИЙН ЭРХЭЭ АВЛАА



Н.ПУНЦАГБОЛД

Нэр хүнд, цар хүрээгээрээ Аваргуудын лигийн дараа орох Европа лигийн финалын тоглолт өнгөрсөн лхагва гарагийн шөнө Шведийн Стокгольм хотын “Френдс Арена” цэнгэлдэх хүрээлэнд боллоо. Европа лигийн финалд Английн алдарт “Манчестер Юнайтед” клуб Голландын “Аякс”-тай тулсан юм. Европа лигт түрүүлж байж ирэх жил Аваргуудын лигийн эрхээ авах байсан “Улаан чөтгөрүүд” даалгавраа амжилттай биелүүлж, өрсөлдөгчөө 2:0-ээр буулгаж авсан юм. Ингэснээр ирэх жил Аваргуудын лигт Английн таван баг харах боломжтой боллоо. Тоглолтын 18 дахь минутад Пол Погба гоолдож, тооны харьцааг нээсэн. Улмаар 48 дахь минутад Мхитарян нэгийг нэмж, багийнхаа хожлыг баталгаажуулсан байна. Ийнхүү “Манчестер Юнайтед” Европа лигт анх удаагаа түрүүлж чадлаа.

Тэдний хувьд премьер лигт дөнгөж зургадугаар байрт орсон. Лигийн топ зургаан багийн өрсөлдөөнд зургадугаар байрт орсон гэсэн үг. Тэгвэл Европа лигт түрүүлснээр ирэх жил аваргуудын лигт орох эрх авсан. Мөн энэ түрүү нь “Манчестер Юнайтед” клубт олон амжилтыг дагуулж авчирлаа. Өмнө нь тэд энэхүү тэмцээнд түрүүлж үзээгүй юм. Харин анх удаагаа түрүүлснээр Европын хэмжээнд гурван янзын цомыг бүгдийг нь авсан тав дахь баг болсон юм. Өөрөөр хэлбэл, Аваргуудын лиг, Европа лиг болон Цомтой багуудын цомд түрүүлж чадсан тавхан багийн нэг боллоо. Өмнө нь “Байерн”, “Ювентус”, “Аякс”, “Челси” клубууд ийм амжилтыг үзүүлж байжээ. “Манчестер Юнайтед”-ын хувьд 1968, 1999, 2008 онд Аваргуудын лигт түрүүлж байсан бол 1991 онд Цомтой багуудын цомыг хүртэж байжээ.

Харин энэ жил Европа лигт хамгийн чухал түрүүгээ хүртэж, ирэх жил томчуудтай тулах нь. Английнпремьерлигтдөрөвдүгээр байрт шалгарсан “Ливерпүүл” урьдчилсан шатны тоглолтод хожиж чадвал Аваргуудын лигт энэ лигийн топ таван багийг харах нь. “Манчестер Юнайтед”-ын хувьд Аваргуудын лигт хоёрдугаар сагсанд багтах юм.

Улс улсынхаа лигт түрүүлсэн найман баг Аваргуудын лигийн хэсгийг тэргүүлэх дүрэмтэй болсон. Тэгвэл “Реал Мадрид”, “Байерн Мюнхэн”, “Ювентус”, “Бенфика”, “Челси”, “Miner”, “Монако”, “Спартак” гэсэн найман баг хэсэг тэргүүлэх нь тодорхой болчихоод байна. Урьдчилсан байдлаар хоёрдугаар сагсанд “Барселона”, “Атлетико Мадрид”, “ПСЖ”, “Боруссия Дортмунд”, “Севилья”, “Манчестер Сити”, “Порто”, “Манчестер Юнайтед” клубууд багтахаар байна. Гуравдугаар сагсанд мөн л урьдчилсан байдлаар “Наполи”, “Тоттенхэм”, “Базель”, “Динамо Киев”, “Аякс”, “Олимпиакос”, “Андерлехт”, “Ливерпүүл” гэсэн багууд багтахаар байгаа юм. Дөрөвдүгээр сагсанд “РБ Лейпциг”, “Фейеноорд”, “Рома”, “Селтик”, “Ницца” багууд багтахаар байна. Мөн л урьдчилсан байдлаар гэдгийг мартаж болохгүй. Тэгээд плей-офф шатны тоглолтын дараа юу ч болж болох юм.

Погба 10 дахь цомоо хүртэж, Ибра Европын тавцанд анх удаа түрүүллээ



“Манчестер Юнайтед” Европа лигт түрүүлж, Аваргуудын лигт орох эрхээ авахын хажуугаар хувь тоглогчид ч гэсэн шинэ шинэ амжилтыг үзүүллээ. Тухайлбал, Европын том багуудад гайхалтай амжилтыг үзүүлж байгаа Швед довтлогч Златан Ибрахимович анх удаа Европын тавцанд түрүүлж байгаа юм. Хэдийгээр финалын тоглолтод Ибра оролцож чадаагүй ч Европа лигт энэ улиралд 11 удаа талбайд гарч, таван гоол оруулж, гурван гоолын дамжуулалт өгсөн билээ. Түүний сайн тоглолт “Улаан чөтгөрүүд”-ийг финалд авчирч, Ибра анх удаа Европын цом өргөлөө. Өмнө нь тэрбээр Европын супер цомыг хүртэж байсан удаатай. Харин Аваргуудын лиг болон Европа лигт түрүүлж үзээгүй байсан билээ.

Тэгвэл финалд нэг гоол оруулсан Пол Погба замналынхаа 10 дахь цомыг хүртлээ. Өмнө нь тэрбээр Италийн Сери А лигийн аваргаар дөрвөн удаа тодорсон. Мөн Италийн цомд болон Супер цомд хоёр удаа түрүүлсэн бол Англид ирээд Английн цомын тэмцээнд түрүүлчихээд байсан юм.





Моуринь гурван өөр багийн хамтаар Европын цом хүртсэн гурав дахь дасгалжуулагч боллоо

“Манчестер Юнайтед”-ын тоглогчдоос гадна дасгалжуулагч Жозе Моуриньо Европа лигт багаа түрүүлүүлснээр гурван өөр клубтэй Европын цом өргөсөн гурав дахь дасгалжуулагч болж чадлаа. Тэрбээр өмнө нь Португалын “Порто”, Италийн “Интер” клубын хамтаар Аваргуудын лигт түрүүлж байсан юм. Харин энэ удаад “Манчестер Юнайтед”-тай Европа лигт түрүүллээ. Өмнө нь энэ амжилтыг Рафаэль Бенитес болон Удо Латтек нар л үзүүлж байжээ. Европа лигт түрүүлсний дараа Жозе Моуриньо “Маш хүнд улирлын ард гарлаа. Гэхдээ энэ улиралд бид маш сайн байсан. Бид премьер лигт топ дөрөвт багтах биш энэ замаар Аваргуудын лигийн эрхээ авахыг сонгосон. Одоо “Манчестер Юнайтед” авч болох бүхий л цомыг авсан баг боллоо. Бид энэ цомыг авч чадна гэдэгтээ үргэлж итгэлтэй байсан. Тиймдээ ч бид бүгдээрээ баяртай байна. “Аякс” хүчтэй өрсөлдөөн үзүүлсэн ч бид хожиж чадлаа. Сүүлийн саруудад олон тоглогч бэртэл гэмтлийн асуудалтай тулгарсан. Гэхдээ л бид гурван цом, аваргуудын лигийн эрхтэй улирлыг дуусгалаа. Энэ миний замналын хамгийн хэцүү улирал байсан ч би аз жаргалтай байна” хэмээн ярьжээ.


## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь “Улаанбаатар хотын гудамж замын өндөржилтийн төлөвлөлт 20855.5 га /БЗД, СБД, ЧД-ийн суурьшлын хэсэг/ 20855.5 га” НХААГ-17/0154 дугаартай ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газраас 2017 онд хийгдэх болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараахи мэдээллийг ирүүлнэ:

• Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

• Тусгай зөвшөөрлийн хуулбар:
  - Барилга хот байгуулалтын яамны 1.1.1. Бүс нутгийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө, хот төлөвлөлтийн суурь судалгаа хийх тусгай зөвшөөрөл
  - Барилга хот байгуулалтын яамны Геодези, зураг зүйн тусгай зөвшөөрөл

• Тус ажлыг хийж гүйцэтгэх инженер техникийн ажилтны дэлгэрэнгүй мэдээлэл, CV

• Сүүлийн 3 жилд /2014, 2015, 2016 он/ хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт, дэлгэрэнгүй мэдээлэл

*Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.*

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 08:00 цагаас 2017 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 17:00 цаг хүртэл авч болох бөгөөд Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр 2017 оны 06 дугаар сарын 07–ны өдрийн 10:00 цагийн дотор ирүүлнэ үү.

**Чингэлтэй дүүрэг, Багатойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, 1011 тоот. Утас: 75757810**


ЭМЧ ЗӨВЛӨЖ БАЙНА

## Зөгийн балаар ханиад дарах арга



Нэг цайны халбага зөгийн балыг 2.5 цайны халбага манжингийн шүүстэй хольж өдөрт дөрвөн удаа, хамрын нүхэндаа тав таван дуслаар дусаах

Бага насны хүүхдэд манжингийн шүүсийг хамарт дусааж хэрэглэнэ

Нярай хүүхдэд нэг цайны халбага зөгийн балыг хоёр цайны халбага бүлээн усанд уусгана. Энэ шингэнээ хөвөнд шингээж хамрын нүхэнд 20 минут орчим байлгана. Хүүхэд тавгүйтэж, уур уцаартай байвал хамрын нүхийг ээлж ээлжээр арчин цэвэрлээрэй.

**Дотор мэдрэлийн сувилагч Т.Гүнжинлхам , Б.Гантулга**
**ЭЭЯТ-ийн сувилагч Б.Энхзул**



## Хоол хүнсний эрүүл ахуй

• Болгосон хоолоо зөв хадгал
• Хоол болгосны дараа хэрэглэхгүй бол аль болох хурдан хүйтэн газар хийж хөлдөөнө.
• Мах, салат зэрэг хөргөгчинд хадгалдаг хүнсний бүтээгдэхүүн болон болсон хоолыг өрөөнд хоёр цагаас илүү хугацаагаар битгий тавь. Бичил биетэн үржих аюултай.
• Хоносон хоолыг хүнсэнд бүү хэрэглэ.
• Баглаа боодолгүй, хугацаа нь дууссан бүтээгдэхүүнийг хүнсэнд бүү хэрэглэ.

**ЭЭЯТ-ийн тасаг сувилагч Х.Ариунболор, А. Энхжаргал**

# СПОРТ

АМЖИЛТЫН ЭЗЭН



# Номура Тадахиро:
# АЙДАС ГЭДЭГ ГАНЦААРДАЛТАЙ ХИЙХ ТЭМЦЭЛ ЮМ

**Төгсгөл.**
**Түрүүч нь V нүүрт**

**-Та гурван олимп дараалан медаль хүртсэн. Тэднээс хамгийн дурсамжтай, басхүү сэтгэлд тод үлдсэн олимп аль нь вэ?**

-Анхны юм бүхэн дурсамжтай байдаг шүү дээ. 1996 оны Атлантагийн олимпод хамгийн анх эх орноо төлөөлөн оролцсон юм. Тэр үе санаанаас огт гардаггүй. Тэгэхэд, заавал медальд хүрэх ёстой гэсэн зорилгыг өөртөө тавьж байсан. Харин миний эргэн тойрны хүмүүс төдийлөн их найдвар тавиагүй юм билээ. Гэтэл 2000 оны Сиднейн олимп эсрэгээрээ байсан. Олон нийтийн дунд алтан медаль авчихаасай гэсэн хэт их хүлээлт үүсчихсэн байв. Тухайн үед би ч сэтгэл санаа, бие махбодийн бэлтгэлээ сайн хангасан учраас өрсөлдөөн ширүүхэн ч, хүссэн амжилтаа үзүүлж чадсан. Хамгийн хэцүү нь гурван жил сэтгэлзүйн дарамт, айдастай тулгарсан. Түүнийгээ даван туулахын тулд “Энэ хүртэл яах гэж жүдогийн спортоор хичээллэсэн билээ дээ. Ирээдүйд өөртөө итгэлтэй, хүссэн зүйлээ нүүр бардам хийхийн тулд эхлээд хоёр олимп дараалан медаль хүртэх хэрэгтэй. Ингэвэл сэтгэл амар зодог тайлж чадна” гэх үгийг өөртөө хэлж зоригжуулж байлаа. Сиднейн олимпийн дараа харин өөрөөсөө “Үнэхээр жүдогийн спортоос зодог тайлах гэж үү” хэмээн асууж, бодлоо цэгцлэхийн тулд жүдогоос хэсэгтээ хөндийрсөн. Хоёр жил орчим завсарлаад жүдогийнхоо дэвжээнд эргэн ирж байлаа. Тэгээд л дахиад нэг удаа олимпийн медаль хүртэхийн тулд шаргуу хичээллэсэн. Олон ч бэрхшээл тулгарсан. Тэр бүрийг даван туулсны эцэст 2004 оны Афены олимпоос гурав дахь медалиа зүүсэн юм. Афен миний хамгийн их зорьж, хүсэн хүлээсэн олимп байсан.

**-Олон нийтийн дунд үүссэн хүлээлт, анхаарал, хайр энэрэлийг даана гэдэг тамирчин хүний хувьд хамгийн хэцүү юм шиг санагддаг?**

-Ерөнхийдөө хийх ёстой зүйлээ сайн хийхийн нэр шүү дээ. Зарим хүмүүсийн ярьж хэлдэг зүйл практикт ямар ч учир утгагүй байдаг юм шиг санагддаг. Миний хувьд ялалт байгуулахын тулд бэлтгэл сургуулилтаас гадна тоглох, сургуулилт хийх гээд ер нь хүний бүхий л үйл ажиллагаа ялж, ялагдахтай холбоотой байдаг гэдгийг ухамсарлах хэрэгтэй гэдгийг ойлгосон. Бусад хүмүүсээс бага хугацаанд бэлтгэл хийж байсан учраас намайг зарим нь “бэлтгэл хийх дургүй, залхуу” гэлцдэг байсан. Гэхдээ тоо хэмжээнээс илүү чанарыг чухалчилж байснаараа би одоо ч бахархдаг.

**-Номура, та өөрийнхөө зан чанарыг тодорхойлохдоо “Чалчаа” гэсэн байсан. Олимп, тэмцээн уралдаанд оролцохдоо огт айдаггүй гэсэн үг үү?**

-Тэмцээний өмнө байнга л айдас мэдрэгддэг. Хэрвээ би ялагдчихвал юу болох бол гэж бодохоор тэмцээний өмнөх өдөр нойр хүрдэггүй юм. Олимпод гурван ч удаа оролцсон атлаа л энэ зуршлаасаа салж чадахгүй байна. Жинхэнээсээ ялагдчихвал өдий хүртэл хичээж зүтгэж ирсэн хөдөлмөр талаар болох учраас айх нь мэдээжийн хэрэг. Би тэмцээнд ялсны дараах өөрийгөө төсөөлөн бодож, сэтгэлзүйн бэлтгэл хийдэг. Энэ тухай бодохоо боливол айдас над руу аажмаар мөлхөн ирнэ. Айхгүйгээр жүдо барилдвал уг нь сэтгэл амар юм даа гэж та бодсон уу. Хэдийгээр би хэт их чалчдаг байж магадгүй ч, юу хийх ёстой, юуг ухамсарлах хэрэгтэй вэ гэдгээ мэднэ. Айдсаа даван туулахын тулд бэлтгэлээ маш сайн хангаж чадсан гэдэгтээ итгэдэг. Тэмцээнд оролцох хүн нь би. Өөр хэн ч биш. Тиймээс айдас гэдэг ганцаардалтай хийх тэмцэл юм.

> ...Дөрөв дэх нь Бээжингийн олимп байлаа. Олимпод оролцох жүдочдын сонгон шалгаруулалтад баруун өвдөгний үений холбоос тасарсан байсан ч гэсэн сургуулилтаа үргэлжлүүлж байв. Гэвч гэмтлийн нөлөөгөөр Бээжингийн олимпод оролцож чадаагүй. Ингэж миний дөрвөн олимпод оролцох мөрөөдөл талаар болсон ч, хүсэл мөрөөдлөө орхихыг хүсээгүй юм даа...

**-Нэг удаа жүдогийн спортоос зодог тайлах тухай бодож байсан гэж та дээр хэлсэн шүү дээ. Тэгсэн атлаа 40 нас хүрчихээд байж жүдогийн дэвжээнээсээ холдож чадахгүй байгаа шалтгаан чинь юу юм бэ?**

-Сиднейн олимпын үеэр хэдий нас ахисан ч, үргэлжлүүлэн барилдсаар байгаа нэг тамирчныг олж харсан юм. Тэгээд “Яагаад өдий хүртэл жүдог орхиогүй юм бол. Аварга болсон бол хангалттай шүү дээ” гэж бодож байв. Харин хоёр дахь олимпоос медаль хүртсэнийхээ дараа зодог тайлах тухай бодож эхэлсэн. Гэтэл Афений олимп болохын өмнө “Зодог тайлна гэх бодлоо толгойноосоо авч хаях хэрэгтэй” гэж бодох болсон. Жүдогийн хөнгөн жинд тамирчны амьдрах хугацаа маш богино байдаг шүү дээ. Угаасаа тухайн үед ч гэсэн нийгэмд “Номура одоо зодог тайлах болсон” гэх яриа ч гарч эхэлсэн байсан юм. Жүдог гэх сэтгэл оршсоор байсан учраас “Эд чинь одоо юугаа ярина вэ” гэсэн хор шар хөдөлж билээ. Дөрөв дэх нь Бээжингийн олимп байлаа. Олимпод оролцох жүдочдын сонгон шалгаруулалтад баруун өвдөгний үений холбоос тасарсан байсан ч гэсэн сургуулилтаа үргэлжлүүлж байв. Гэвч гэмтлийн нөлөөгөөр Бээжингийн олимпод оролцож чадаагүй. Ингэж миний дөрвөн олимпод оролцох мөрөөдөл талаар болсон ч, хүсэл мөрөөдлөө орхихыг хүсээгүй юм даа.

**-Та жүдочдын гэр бүлд төрсөн. Гэр бүлийн ямар орчинд өсч, хүмүүжсэн бэ?**

-Өвөө маань “Хотокүкан” гэх дэвжээг нээж байсан. Харин аав Тэнри ахлах сургуулийн жүдо бөхийн дугуйлангийн багшаар олон жил ажилласан бол авга ах Мюнхэний олимпоос алтан медаль хүртэж байсан удаатай. Өвөө ч, аав ч жүдочдын гэр бүл гэдэг утгаар аливаа дарамт шахалт үзүүлэлгүй өсгөсөн. Намайг заавал жүдогоор хичээллэх хэрэгтэй гэж хүчээр шахаж байгаагүй учраас эхэндээ би усанд сэлэлт, бэйсболоор хичээллэж байсан. Сургуульд ч сурч билээ. Аав надад шууд жүдо заах боломж маш бага учраас жүдо цэвэр миний өөрийн сонгосон зам байсан. Надад маш олон сонголтыг бүтээж өгсөн эцэг эхдээ үнэхээр их баярладаг. Тэд маань надад бүхнээ зориулдаг байсныг өөрөө эцэг болсон хойноо л ухаардаг юм байна. Хоёр хүүхэддээ ч гэсэн өвөө эмээ нь надад яаж handдаг байсан яг түүн шиг өөрсдийнх нь дуртай зүйлд нь урам өгч, янз бүрийн туршилт хийхэд нь туслахыг эрмэлздэг. Бас эцэг хүнийхээ хувьд нэг л зүйлд бүхнээ зориулах хэрэгтэй гэдгийг хүүхдүүддээ өөрийн биеэр үлгэрлэж харуулахыг хүсдэг.

**-Мөрөөдлөө биелүүлэхийн тулд хамгийн чухал зүйлийн талаар та өөрийн туршлагаасаа бидэнд хуваалцаач?**

-Намайг амжилт гаргаж эхлэх тэр үед хүмүүс “Номурагийн мэх их уран ” гэж ярьдаг байлаа. Гэтэл дунд, ахлах сургуульд байхдаа би хэчнээн хичээгээд ч амжилт гаргаж чаддаггүй байсан юм. Үеийнхнээсээ нуруу нам, туранхай байж билээ. Ойр тойрны хүмүүс сул дорой гэж шоолдог байв. Тухайн үед эцэг эх минь надад санаа тавьдаг байсан ч, тэд ч гэсэн надад тийм их найдвар тавьж байгаагүй болов уу гэж боддог. Хэнд ч ялагдахгүй, тэднээр бахархуулахын тулд хамгийн дуртай жүдогоороо үргэлжлүүлэн хичээллэсэн. Надад авьяас чадвар байсан учраас тэр авьяасаа хөгжүүлнэ гэсэн итгэл бас хүсэл байсан. Яг үүн шиг олон жил зарцуулсан ч хамаагүй мөрөөдлийнхөө төлөө зүтгэх л хэрэгтэй. Азаар би багаасаа жүдогоор хичээллэсэн юм даа. Тиймээс залуустаа хандаж, заавал өөрийнхөө дуртай зүйлээ олж, хэн нэгний төлөө биш өөрийнхөө төлөө бүхий л чадлаараа хөдөлмөрлөх л хамгийн чухал юм шүү гэдгийг хэлмээр байна. Спортод хичээл сургуулилт, хөдөлмөргүйгээр амжилт гаргана гэж байдаггүй юм.


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Тендер шалгаруулалтын нэр:** Гэр хорооллын үерийн хамгаалалтын суваг
**Тендер шалгаруулалтын дугаар:** ОР-155/2017
**Огноо:** 2017-05-24

Орхон аймгийн засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Гэр хорооллын үерийн хамгаалалтын суваг хийх ажил–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100.000 /нэг зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

**Төрийн сан** 9025
**Дансны дугаар:** 100210051424
**Хүлээн авагч:** ОР.ОНӨГ нэмэлт санхүүжилт

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх

Санал болгож буй үнийн дүнгээс багагүй хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээл авах боломжтой байх

2014, 2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх

Дараах тусгай зөвшөөрөлтэй байх: Барилга хот байгуулалтын яамны 2.3.2-Хөрсний ус доошлуулах, шүүрүүлэх, эргийн бэхэлгээ, далан суваг үүний дотор төмөр замын далан, хоолой болон газар шорооны тусгай ажил

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн [1%] төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 08 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 08 цаг 30 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн удирдлагын ордон**
**1 давхар 113 тоот өрөө Утас:70358570**



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Тендер шалгаруулалтын нэр:** Гэр хорооллын үерийн хамгаалалтын суваг (1-р хэсэг)
**Тендер шалгаруулалтын дугаар:** ОР-73/2017
**Огноо:** 2017-05-24

Орхон аймгийн засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Гэр хорооллын үерийн хамгаалалтын суваг (1-р хэсэг) ажил–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100.000 /нэг зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.
**Төрийн сан** 9025
**Дансны дугаар:** 100210051424
**Хүлээн авагч:** ОР.ОНӨГ нэмэлт санхүүжилт
Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.
Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх

Санал болгож буй үнийн дүнгээс багагүй хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээл авах боломжтой байх

2014, 2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх

Дараах тусгай зөвшөөрөлтэй байх: Барилга хот байгуулалтын яамны 2.3.2-Хөрсний ус доошлуулах, шүүрүүлэх, эргийн бэхэлгээ, далан суваг үүний дотор төмөр замын далан, хоолой болон газар шорооны тусгай ажил

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн [1%] төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 08 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 08 цаг 30 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн удирдлагын ордон**
**1 давхар 113 тоот өрөө Утас:70358570**

# СПОРТ

ЖУДО

# ЖҮДО БӨХИЙН АЗИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН ӨНӨӨДӨР ЭХЭЛНЭ

Н.БОЛД

Жүдо бөхийн насанд хүрэгчдийн Азийн аварга шалгаруулах тэмцээн өнөөдөр Хонгконгод эхлэх учиртай. Энэ удаагийн Азийн аваргад 28 орны эрэгтэй 141, эмэгтэй 101, нийт 242 тамирчин оролцохоор мэдүүлгээ өгөөд байгаа аж. Харин манайхаас эрэгтэй ес, эмэгтэй найм, нийт 17 жүдоч оролцох ажээ. Азийн аваргын хэсгийн барилдаан өглөө 09:00 цагаас эхэлнэ. Харин финалын барилдаан 16:00 цагт эхлэх бөгөөд МҮОНТ, ЕТВ, SPS телевиз шууд дамжуулан үзүүлэх юм байна. Энэ жилийн Азийн аваргад оролцох манай жүдогийн шигшээ багт шинэ залуу тамирчид цөөнгүй багтаж байгаагаараа онцлог. Тухайлбал, 60 кг-ын жинд Ж.Амарболд, Г.Хэрлэн явж байгаа бол 90 кг-д Г.Алтанбагана өрсөлдөнө. Бас нэг шинэ мэдээ байгаа нь 90 кг-ын жинд Абу Дабигийн “Их дуулга” тэмцээнд түрүүлж, Рио-2016 Олимпийн наадамд тавдугаар байрт шалгарч явсан Л.Отгонбаатар -100 руу өгссөн.



Мөн манай эрэгтэй баг тамирчид 81, -100 кг-д хоёр хоёр бөх илгээсэн нь тун сонирхол татаж байна. Эмэгтэйчүүдийн хувьд 52 кг-д Ч.Аззаяа, Л.Сосорбарам гэсэн хоёр залуу тамирчин өрсөлдөхөөр болсон. Мөн 63 кг-д Б.Ганхайч, 70-д Б.Хулан гэсэн шинэ залуу тамирчид оролцохоор болсон юм. 2016 оны жүдо бөхийн ААШ тэмцээн дөрөвдүгээр сарын дундуур болж, манай бөхчүүд 11 медаль хүртсэн гайхалтай амжилтыг үзүүлж байлаа. Тухайлбал, эрэгтэйчүүдээс 66-д Д.Алтансүх, 81-д Н.Дагвасүрэн, -100-д Н.Түвшинбаяр, эмэгтэйчүүдээс Д.Сумъяа алт авсан. Алтан медалийнхаа тоогоор Японтой эн зэрэгцсэн. Багийн дүнгээр Японы араас хоёрдугаар байрт шалгарч байлаа.

Мөнгөн медалийн тоогоор ард нь орчихсон болохоос М.Уранцэцэг алт авчихсан бол багийн дүнгээр түрүүлэх ч боломжтой байсан. Гэвч М.Уранцэцэг Казахстаны нэрийн өмнөөс барилдсан Г.Отгонцэцэгт ялагдсанаар боломжоо алдаж байсан билээ. Тэгвэл энэ жил ч гэсэн өндөр амжилт үзүүлэх боломж байгаа. Мөн 48 кг-д М.Уранцэцэг, Г.Отгонцэцэг нарын хооронд тэмцэл өрнөж магадгүй. Мөн Япон, Солонгосын бөхчүүдийг ч мартаж болохгүй юм.

**Монголын шигшээ багийн бүрэлдэхүүн**

**Эрэгтэй баг:**
-60кг: Жагваралдожийн Амарболд
-66кг: Ганболдын Хэрлэн
-73кг: Ганбаатарын Одбаяр
-81кг: Нямсүрэнгийн Дагвасүрэн
-81кг: Отгонбаатарын Ууганбаатар
-90кг: Гантулгын Алтанбагана
-100кг: Бунддоржийн Жанчивдорж
-100кг: Лхагвасүрэнгийн Отгонбаатар
+100кг: Өлзийбаярын Дүүрэнбаяр
+100кг: Найдангийн Түвшинбаяр

**Эмэгтэй баг**
-48кг: Мөнхбатын Уранцэцэг
-52кг: Чинтогтохын Аззаяа
-52кг: Лхагвасүрэнгийн Сосорбарам
-57кг: Доржсүрэнгийн Сумъяа
-63кг: Балдоржийн Мөнгөнчимэг
-63кг: Болдын Ганхайч
-70кг: Батбаатарын Хулан
+78кг: Баттулгын Мөнхтуяа

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ




Олон улсын жүдо бөхийн холбоо энэ сарын 22-ны өдөр бөхчүүдийн шинэчилсэн чансааг гаргалаа. Манайхаас Д.Сумъяа, М.Уранцэцэг нар дэлхийн чансааг тэргүүлж байсан. Тэгвэл шинэ чансааны дараа М.Уранцэцэг гуравдугаар байр руу ухарч, Д.Сумъяа тэргүүллээ хадгалж үлдлээ. Тэгвэл, эрэгтэйчүүдээс 60 кг-ын жинд Д.Амартүвшин тав, Г.Болдбаатар ес, Б.Амартүвшин 39, Ж.Амарболд 47, Ц.Цогтбаатар 48 дугаар байрт бичигдэж байна. Харин 66 кг-д Д.Төмөрхүлэг хоёрдугаар байрт бичигдэж буй бол 73-т Г.Одбаяр зургадугаарт жагслаа. 81 кг-ын хувьд Н.Дагвасүрэн 10 дугаар байрт бичигдсэн бол О.Уугaнбаатар 25-д эрэмбэлэгдсэн. 90 кг-д Г.Алтанбагана хүч түрэн орж ирж, 17 дугаарт жагссан бол Л.Отгонбаатар 22 дугаар байрт бичигдсэн юм. -100-д одоо барилдаж байгаа бөхчүүдээс Х.Цогтгэрэл л 67 дугаар байрт бичигдсэн бол +100 кг-д Ө.Дүүрэнбаяр 19, Б.Тэмүүлэн 23 дугаар байрт бичигдсэн байна. Эмэгтэйчүүдээс 48 кг-д М.Уранцэцэг нэгдүгээр байраа Г.Отгонцэцэгт алдаж, гурав руу ухарлаа. 52-т А.Цолмон 32, 57-д Д.Сумъяа нэгдүгээрт бичигдлээ. 63 кг-ын хувьд Ц.Цэрэннадмид 23, 70-д Ц.Наранжаргал 34, -78-д мөн Ц.Наранжаргал 52, +78-д Б.Мөнхтуяа 36-д бичигджээ.

## Чөлөөтийн тамирчид Японд Олимпийн бэлтгэл хийнэ

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдын урилгаар айлчилж байгаа Япон Улсын "Мияконожо" хотын дарга Икэда Такахиса тэргүүтэй төлөөлөгчид өчигдөр УИХ-ын дарга М.Энхболдод бараалхлаа. Уулзалтын үеэр Ноён Икэда Такахиса УИХ-ын даргыг хүлээн авч уулзаж буйд талархлаа илэрхийллээ. Тэрбээр “Токио 2020” олимпийг угтан өргөн хүрээний ажлууд хийгдэж байна. Энэ хүрээнд манай “Мияконожо” хотод Монголын чөлөөт бөхийн шилдэг тамирчдыг урьж, бэлтгэл сургуулилт хийлгэхээр болсон. Энэ ажлыг ирэх жилийн хоёрдугаар сард зохион байгуулахаар төлөвлөж байгаагаа дуулгалаа. 2019 онд хотууд найрамдлын харилцаа тогтоосны 20 жилийн ойгоо тэмдэглэх бөгөөд энэ ойн баярт УИХ-ын дарга М.Энхболдыг урьсан байна.

## Ники Хейден эрхтний донор болно

Зам тээврийн ослоор нас барсан 2006 оны MotoGP ангиллын тойрог замын мотоциклын уралдааны дэлхийн аварга Ники Хейден өөрийн эд эрхтэнүүдийг хэрэгтэй хүмүүст нь өгөхийг гэрээсэлжээ. Энэ тухай Италийн “Askanews” цахим хуудсанд бичсэн байна.

Америкийн тамирчин тавдугаар сарын 17-нд Италийн Римини хотод дугуй унаж яваад автомашинд дайруулжээ. 35 настай тамирчин толгой, цээжин биендээ хүнд гэмтэл авч эмнэлэгт хүргэгдсэн бөгөөд түүний биеийн байдал нь маш хүнд байжээ. Тэрбээр даваа гарагт нас барсан байна. Н.Хэйдений гэр бүлийнхэн эрхтэний донор болоход шаардагдах баримт бичгүүдийг бүрдүүлэхийг зөвшөөрчээ. Н.Хэйден 2003-2005 онд MotoGP ангиллын уралдаанд оролцож байв. 2006 онд тэрбээр Honda багийн бүрэлдэхүүнд дэлхийн аварга болж байсан ба 2016 оноос хойш “Superbike” ангилалд уралдах болжээ.



Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 18
Шөнө 11

Нөгөөдөр
Өдөр 20
Шөнө 3

## Өдрийн зурхай

**ЗУНЫ ЭХЭН ХӨХӨГЧИН МОГОЙ САР ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ҮХЭР ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 05.02-20.36

**Үс засуулбал:** Нас ахар болно



*Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр аливаа үйлс сэтгэлчлэн бүтнэ. Шүтээн босгох, хот балгадыг барих, тариа тарих, худалдаа наймаа хийх, хувцас хийх, гэр орон барих, сан нуун дарах, шид бүтээл үйлдэх тарни тоолох болон дэлгэрүүлэх үйл бүхнээ сайн болой. Зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олдох, зүүн чих хангинавал аймшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэмцэл болох, хэрээ дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болно. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой.*


